

Дундговь аймаг дахь
Төрийн аудитын газар



ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

“ТӨРӨӨС ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХ, АЖЛЫН
БАЙРЫГ НЭМЭГДҮҮЛЭХ ЧИГЛЭЛЭЭР АВЧ
ХЭРЭГЖҮҮЛСЭН БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН”-Д
ХИЙСЭН ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

АУДИТЫН КОД: ДУА-2022/20-ШТА-ГА

Дарга, Тэргүүлэх аудитор Р.Мөнхтогтох
Утас: 70592439,
Аудитын менежер Х.Наранцацрал
Утас: 70592225
Цахим хаяг: dundgovi@audit.gov.mn
Ахлах аудитор Ч.Бэрхсайхан
Аудитор Ж.Угтахбаяр
Аудитор Л.Уранбилэг
Утас: 70593208

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт
мэдээллийг дараах хаягаар авна уу. Цахим
хуудас: www.audit.mn



ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН
ТУШААЛ

2022 оны 05 сарын 05 өдөр

Дугаар 09

Мандалговь

Аудитын тайланг
баталгаажуулах тухай


Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 29 дүгээр зүйлийн 29.4, Монгол Улсын Ерөнхий аудиторов 2018 оны А/207 дугаар тушаалаар батлагдсан “Аймаг нийслэл дэх Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторт шилжүүлэх эрх үүрэг”-ийн 1.1, 1.3, Монгол Улсын Ерөнхий аудиторов 2020 оны А/106 дугаар тушаалаар батлагдсан “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”-ын 18 дугаар зүйлийн 9-т заасныг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. “Төрөөс хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх чиглэлээр авч хэрэгжүүлсэн бодлогын хэрэгжилт, үр дүн”-д хийсэн аудитын тайлан /ДУА-2022/20-10-ШТА-ГА/-г нэгдүгээр, аудитаар илэрсэн зөрчлийн жагсаалт (төлбөрийн акт, албан шаардлага) –ыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. “Төрөөс хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх чиглэлээр авч хэрэгжүүлсэн бодлогын хэрэгжилт, үр дүн”-д хийсэн аудитын тайланг Үндэсний аудитын газар, аймгийн Засаг дарга, аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын даргад тус тус хүргүүлсүгэй.

3. Гүйцэтгэлийн аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтийг бүрэн хангуулан, үр дүнгийн талаар 2022 оны 10 дугаар сарын 25-ны дотор Төрийн аудитын газарт хариу ирүүлэхийг Дундговь аймгийн Засаг дарга /Ц.Мөнхбат/, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар /Г.Хишигдаваа/-т зөвлөсүгэй.

Аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг тооцон 2022 оны 4 дүгээр улиралд танилцуулахыг Аудитын гуравдугаар нэгжийн ахлах аудитор /Ч.Бэрхсайхан/, аудитор /Ж.Угтахбаяр/, аудитор /Л.Уранбилэг/ нарт үүрэг болгосугай.



Р.МӨНХТОГТОХ

0012010158

<u>Тайланг бэлтгэсэн:</u>	Товчилсон үгс	4
Дундговь аймаг дахь Төрийн аудитын газар	Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй	5-8
	Дүрслэлийн товчёг	9-10
Дарга, тэргүүлэх аудитор Р.Мөнхтогтох	<u>Бүлэг 1. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэхтэй холбоотой ажил хариуцсан байгууллага хоорондын уялдаа холбоо муу, хөдөлмөр эрхлэлтийн аймгийн зөвлөл дүрэмд заасан чиг үүргээ хэрэгжүүлээгүй зэргээс аймгийн бодлого төлөвлөлт хангалтгүй байна.</u>	11-14
Аудитын менежер Х.Наранцацрал	1.1 Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэхтэй холбоотой аймгийн бодлого, төлөвлөлт хангалтгүй, хоорондын уялдаа холбоо муу байна.	11-12
Ахлах аудитор	1.2 Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх бодлогыг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг тооцоо судалгаанд үндэслэн төлөвлөөгүй байна.	12-12
Ч.Бэрхсайхан	1.3. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих салбарын төрийн байгууллагуудын үйл ажиллагааны уялдаа холбоо муу байна.	13-14
Аудитор	<u>Бүлэг 2. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажилгүйдлийг бууруулах, ажлын байрыг нэмэгдүүлэх чиглэлээр хэрэгжүүлсэн үйл ажиллагааны үр дүн, хөрөнгийн зарцуулалтын үр ашиг багатай байна.</u>	14-27
Ж.Угтахбаяр	2.1 Хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээнд хамаарах зорилтот бүлгийг тодорхойлоогүй, түүнд чиглэсэн арга хэмжээ хангалтгүй байна.	14-17
Л.Уранбилэг	2.2 Аймгаас хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажилгүйдлийг бууруулах, ажлын байр нэмэгдүүлэх чиглэлээр хэрэгжүүлсэн арга хэмжээг сайжруулах шаардлагатай байна.	17-20
Аудитын тайлан, дүгнэлттэй холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 70593208 дугаарын утас, 70592439 дугаарын факсаар харилцана уу.	2.3 Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн хөрөнгийг бүрэн төвлөрүүлээгүй, сангийн хөрөнгийг хуулийн дагуу зарцуулсан ч үр нөлөөг тооцон ажиллаагүй байна.	20-27
ХАЯГ:	2.4 "Ковид-19" цар тахлын үед хөдөлмөр эрхлэлтийн талаар төрөөс авч хэрэгжүүлсэн арга хэмжээ нь санхүү, үйл ажиллагааны хүндрэлд орсон ААНБ, хувиараа хөдөлмөр эрхлэгчид чиглэгдэж чадаагүй байна.	27-27
Сайнцагаан сум 7-р баг, Нутгийн удирдлагын ордон, 213 тоот	Дүгнэлт	28
2022 оны 5 дугаар сар	Зөвлөмж	29
	Дээд шатны байгууллагад өгөх санал	30
	Санал тайлбар	31

ТОВЧИЛСОН ҮГС

ААНБ	Аж ахуйн нэгж, байгууллага
АДБОУБ	Аудитын дээд байгууллагуудын олон улсын байгууллага
АДБОУС	Аудитын дээд байгууллагуудын олон улсын стандарт
ЖДҮ	Жижиг дунд үйлдвэрлэл
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
НДХ	Нийгмийн даатгалын хэлтэс
СХС	Сум хөгжүүлэх сан
ХНХЯ	Хөдөлмөр нийгмийн хамгаалалын яам
ХХҮГ	Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар
ХХҮЕГ	Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар
ХЭАЗ	Хөдөлмөр эрхлэлтийн аймгийн зөвлөл
ХЭДС	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан
ХНХС	Хөдөлмөр нийгмийн хамгаалалын сайд
ХНХЯ	Хөдөлмөр нийгмийн хамгаалалын яам

АУДИТЫН ЗОРИЛТ, ХАМАРСАН ХҮРЭЭ, АРГА ЗҮЙ, ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

Аудит хийх үндэслэл, бүрэн эрх:

Аудитыг Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд УИХ-ын Төсвийн байнгын хорооны 2021 оны 6 дугаар тогтоол, МҮЕА-ын 2022 оны А/12 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагын 2022 онд гүйцэтгэх аудитын төлөвлөгөө”, Дундговь аймаг дахь Төрийн аудитын газрын 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг үндэслэн гүйцэтгэлээ.

Аудитын зорилго, зорилт:

Төрөөс хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх чиглэлээр авч хэрэгжүүлсэн бодлогын хэрэгжилт, үр дүнг тооцож, дүгнэлт, зөвлөмж боловсруулж, холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилго чиглэнэ.

Аудитын зорилгыг хангахын тулд аудитыг дараах дэд зорилтын хүрээнд гүйцэтгэлээ. Үүнд:

1. Төрөөс хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх чиглэлээр авч хэрэгжүүлсэн бодлогын баримт бичиг, мөн төрийн байгууллагуудын бүтэц, чиг үүргийн уялдаа холбоо хангагдсан эсэх;
2. Төрөөс хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажилгүйдлийг бууруулах, ажлын байрыг нэмэгдүүлэх чиглэлээр хэрэгжүүлсэн үйл ажиллагааны үр дүн, хөрөнгийн зарцуулалт үр ашигтай байгаа эсэх;

Аудитад ашигласан шалгуур үзүүлэлт:

Аудитад дараах хууль, тогтоомж, дүрэм, журам, стандартыг шалгуур үзүүлэлт болгон ашиглав.

- ✓ Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хууль;
- ✓ Нийгмийн даатгалын тухай хууль;
- ✓ Нийгмийн халамжийн тухай хууль;
- ✓ Нийгмийн халамжийн сан;
- ✓ Хөгжлийн бэрхшээлтэй иргэний хүний эрхийн тухай хууль;
- ✓ Дундговь аймгийн 2016-2021 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх хэрэгжилт;
- ✓ Дундговь аймгийг 2018-2028 онд хөгжүүлэх хэтийн зорилт
- ✓ Дундговь аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл

Аудитын хамарсан хүрээ:

Аудитад Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн хүрээнд Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 320 дугаар тогтоолоор баталсан “Төрөөс хөдөлмөр эрхлэлтийн талаар баримтлах бодлогын баримт бичиг”-т тусгасан төсөл, хөтөлбөр зорилго, зорилт, арга хэмжээг хариуцан хэрэгжүүлэх, биелэлтийн явц, үр дүнг тооцон тайлагнах, үнэлж дүгнэх үүрэг хүлээсэн Дундговь аймгийн Хөдөлмөр эрхлэлтийн аймгийн зөвлөл, ХХҮГ, Дэлгэрцогт, Эрдэнэдалай сумдын 2016-2021 оны үйл ажиллагааг хамрууллаа. Хөдөлмөр эрхлэлттэй холбоотой санал асуулгыг 16 төрлийн асуумжаар аймгийн ажил эрхлээгүй 103 иргэнийг хамруулан авч нэгтгэлээ.

Аудитыг АДБОУС 100, 300, 3000-3100, Монгол Улсын Төрийн аудитын стандарт MNS 6817-5:2020 Гүйцэтгэлийн аудитын зарчим, MNS 6817-7:2020

Аудитын арга зүй:	Гүйцэтгэлийн аудитын стандарт, “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”, “Гүйцэтгэлийн аудитын заавар, аргачлал”-ын дагуу аудитын зорилго, зорилт, асуудлын шинжилгээний асуултад хариулт өгөхөд шаардагдах бүх төрлийн нотлох баримт, тоон мэдээллийг холбогдох газруудаас цуглуулан авч, баримтжуулан, тэдгээрийг нягтлан шалгах, дүн шинжилгээ, харьцуулалт, тулган баталгаажуулалт хийх арга зүйг ашиглалаа.
Аудит хийх багийн бүрэлдэхүүн, хугацаа:	Аудитыг Дундговь аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Р.Мөнхтогтох хянан удирдаж, үе шатны чанарын хяналтыг аудитын менежер Х.Наранцацрал хэрэгжүүлж, ахлах аудитор Ч.Бэрхсайхан, Ж.Угтахбаяр, Л.Уранбилэг нар төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу гүйцэтгэсэн. Хөдөлмөр эрхлэлт хариуцсан байгууллага, мэргэжилтний зүгээс тоон мэдээлэл хангалтгүй цуглуулсан, дүн шинжилгээ хийддэггүйн улмаас аудитын гүйцэтгэлийн үе шатанд ажиллагчид, ажил хайгчид болон хөдөлмөр эрхлэлттэй холбоотой тоон мэдээллийг цуглуулан дүн шинжилгээ хийхэд цаг хугацаа алдсан.
Хүндрэл бэрхшээл:	Хөдөлмөр эрхлэлт нь хөгжлийн бодлогын тэргүүлэх чиглэлийн гол үндэс болохын хувьд УИХ, Засгийн газар хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх чиглэлээр төрөөс баримтлах бодлого, хууль, эрх зүйн баримт бичгийг батлан, төсөл, хөтөлбөрүүд хэрэгжүүлж байна. Монгол Улсад хөдөлмөр эрхлэлтийн харилцааг Хөдөлмөрийн тухай хууль, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хууль, Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хууль, Нийгмийн даатгалын тухай хууль, Гадаадад ажиллах хүч илгээх, гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авах тухай хууль, Нийгмийн даатгалын сангаас ажилгүйдлийн тэтгэмж олгох тухай, Нийгмийн халамжийн тухай хууль болон бусад хууль тогтоомжоор зохицуулж байна.
ҮНДСЭН МЭДЭЭЛЭЛ	Монгол Улс нь "Хөдөлмөр эрхлэлтийн хувийн байгууллагын тухай олон улсын хөдөлмөрийн байгууллагын 181 дүгээр конвенц"-ийг 2015 онд, "Хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээний тухай олон улсын хөдөлмөрийн байгууллагын 88 дугаар конвенц"-ийг 2016 онд соёрхон баталсан байна. Монгол Улсын хөдөлмөр эрхлэлтийн харилцаанд эдгээр конвенцод заасан хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээ үзүүлэх үндэсний сүлжээг бүрдүүлж хөгжүүлэх, үйлчилгээний хүртээмж, чанарыг нэмэгдүүлэх, удирдлага, зохион байгуулалт, хүний нөөцийн чадавхыг бэхжүүлэх үүргийг хүлээжээ. Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 320 дугаар тогтоолоор “Төрөөс хөдөлмөр эрхлэлтийн талаар баримтлах бодлого”-ыг баталсан нь хөдөлмөр эрхлэлтийг дэмжих бодлогын ерөнхий хүрээ болсон юм. Энэхүү баримт бичиг нь 2015 онд НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 70 дугаар чуулганаар баталсан “Тогтвортой хөгжлийн зорилго–2030”-ийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлийн зорилтуудтай уялдсан байх шаардлагатай юм. Дундговь аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх, бодлогын хэрэгжилтийг хангах хүрээнд 2016-2021 онд 3,120,572.3 мянган төгрөгийг зарцуулсан байна. Уг зардлыг хэрэгжүүлсэн хөтөлбөр, зарцуулсан хөрөнгөөр ангилан харууллаа. /Хүснэгт 1/ <i>Хүснэгт 1. Хөдөлмөр эрхлэлтэд 2016-2021 онд хэрэгжүүлсэн хөтөлбөр, зарцуулсан хөрөнгийн хэмжээ</i> /мянган төгрөг/

№	Хэрэгжүүлсэн хөтөлбөрүүд	Хэрэгжүүлсэн он	Зарцуулсан хөрөнгийн дүн
1	Хөдөлмөр эрхлэлтийн ур чадвар олгох, ажлын байр хадгалах хөтөлбөр	2016-2021	82,063.9
2	Хувиараа хөдөлмөр эрхлэгч, нөхөрлөл хоршоо байгуулах иргэнийг дэмжих хөтөлбөр	2016	155,023.8
3	Ажлын байрыг дэмжих хөтөлбөр	2016-2020	930,386.2
4	Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээг хөгжүүлэх хөтөлбөр	2017-2021	134,345.5
5	Залуучууд мэргэжлийн боловсрол сургалтын байгууллагын төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр	2016-2021	505,690.7
6	Хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрыг дэмжих хөтөлбөр	2016-2021	311,256.4
7	Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр	2016-2020	859,191.4
8	Цар тахлын үеийн аж ахуй эрхлэгчдийн үйл ажиллагааг сэргээх хөтөлбөр	2021	259,114.5
Нийт дүн			3,237,072.4

*Эх сурвалж: Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар

Хөдөлмөр эрхлэлтийн салбарын 2016-2021 оны нийт зарлагын 57.3 хувийг ажлын байрыг дэмжих хөтөлбөр, малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр, 22.4 хувийг залуучууд мэргэжлийн боловсрол сургалтын байгууллагын төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр, хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрыг дэмжих хөтөлбөр, 20.3 хувийг бусад хөтөлбөр эзэлж байна.

2016-2020 оны хөдөлмөр эрхлэлт, ажилгүйдлийн үзүүлэлтийг доорх хүснэгтэд он тус бүрээр дэлгэрэнгүй харууллаа /Хүснэгт 2/

Хүснэгт 2. Дундговь аймгийн хөдөлмөр эрхлэлт, ажилгүйдлийн зарим үзүүлэлт /хувь/

Үзүүлэлт	2016	2017	2018	2019	2020
15 ба түүнээс дээш насны хүн амын тоо	30.1	30.5	30.8	31.0	31.5
Ажиллах хүч	22.2	23.7	24.5	23.2	22.1
Ажиллах хүчинээс гадуурх хүн ам	8.0	6.8	6.3	7.8	9.4
Ажиллагчдын тоо	21.1	22.6	23.3	22.0	21.5
Ажилгүй иргэдийн тоо	1.1	1.0	1.2	1.1	0.7
Бүртгэлтэй ажилгүй иргэдийн тоо	0.5	0.6	0.5	0.4	0.5
Ажлын байранд зуучлагдсан	0.3	0.5	0.6	0.6	0.6
Ажилгүйдлийн түвшин /хувиар/	5.1	4.4	5	4.9	3.1
Хөдөлмөр эрхлэлтийн түвшин /хувиар/	70.1	74.1	75.6	71.1	68.1

Эх сурвалж: Дундговь аймгийн Статистикийн хэлтэс

Статистик мэдээллээс харахад хөдөлмөр эрхлэлтийн түвшин 2018 онд хамгийн өндөр буюу 76.5 хувь байсан бол, 2020 онд хамгийн бага буюу 68.1 хувьтай байсан байна.

Дэлхий нийтийг хамарсан КОВИД-19 цар тахалтай холбоотой бүх нийтийг хамарсан хөл хорио тогтоох, ААНБ-ын үйл ажиллагааг түр зогсоох гэх мэт арга хэмжээ авсан нь хөдөлмөр эрхлэлтийн салбарт үзүүлсэн үр нөлөөг үнэлэх шаардлагыг бий болгож байна.

Хүснэгтийн товч


№	Тайлбар	Хуудасны дугаар
Хүснэгт 1	Хөдөлмөр эрхлэлтэд 2016-2021 онд хэрэгжүүлсэн хөтөлбөр, зарцуулсан хөрөнгийн хэмжээ	
Хүснэгт 2	Дундговь аймгийн хөдөлмөр эрхлэлт, ажилгүйдлийн зарим үзүүлэлт /хувь/	11
Хүснэгт 3	Ажил хөдөлмөр эрхлээгүй нэг хүнд ногдох зээл	
Хүснэгт 4	Хөтөлбөрт зарцуулсан хөрөнгө, хамрагдсан иргэдийн тоо /2016-2021/	15
Хүснэгт 5	Та ажил хайх ямар оролдлого хийсэн бэ? /судалгаа/	16
Хүснэгт 6	Та төрөөс хэрэгжүүлж буй ажил эрхлэлтийг нэмэгдүүлэх, дэмжих арга хэмжээний талаарх мэдээллийг хаанаас авдаг вэ?/ судалгаа/	18
Хүснэгт 7	Таны ажил хөдөлмөр эрхлэхгүй байгаа шалтгаан юу вэ? судалгаа	20
Хүснэгт 8	Хөдөлмөрийн насны эзлэх хувь /судалгаа/	
Хүснэгт 9	ХХҮЕГ-аас сангийн эх үүсвэрийг авсан судалгаа /2016-2021/	22
Хүснэгт 10	Ажлын байрыг дэмжих хөтөлбөрийн хүрээнд авсан санхүүжилт	24
Хүснэгт 11	ХБИ-д зориулсан байнгын ажлын байрыг нэмэгдүүлэх судалгаа /2016-2021/	
Хүснэгт 12	Малчны хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийн судалгаа /2016-2021/	
Хүснэгт 13	Залуучуудын хөдөлмөр эрхлэлт, гарааны бизнесийг дэмжих хөтөлбөр судалгаа /2016-2021/	
Хүснэгт 14	Залуучуудын хөдөлмөр эрхлэлт, гарааны бизнесийг дэмжих хөтөлбөрсудалгаа/2021-2016/	
Хүснэгт 15	Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээг хөгжүүлэх хөтөлбөр судалгаа/2021-2016/	
Хүснэгт 16	"Ковид-19" цар тахлын үед хөдөлмөр эрхлэлтийн талаар төрөөс авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, зээл олголтын судалгаа /2016-2021/	

Дүрслэл товьёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
Дүрслэл 1	Ажил олгоход хүндрэлтэй иргэн /Жилээр/	19
Дүрслэл 2	ажил хайгчийн тоо ажилд зуучилсан тоо /2019-2021/	23
Дүрслэл 3	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих 5 арга хэмжээ хэрэгжилт /2016-2021/	23
Дүрслэл 4	Ажилгүйдлийн түвшин улсын дундажтай харьцуулсан /2016-2021/	24
Дүрслэл 5	Хөдөлмөр эрхлэлтийн түвшин /2016-2021/	
Дүрслэл 6	Эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлт /хувиар/	
Дүрслэл 7	Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих зээл, хөдөлмөрийн насны 1 хүнд ногдох малын тооны эрэмбийн харьцаа /Сумдаар/	

Хавсралтын товьёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
Хавсралт 1	Аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр, эдийн засаг нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлд хөдөлмөр эрхлэлттэй холбоотой тусгагдсан заалтууд	32-33
Хавсралт 2	Аймгийн Политехникийн коллежийн батлагдсан төсөв, төгсөгчдийн тоо /2016-2021 он/	34-37
Хавсралт 3	Аймгийн Засаг дарга, ХХҮЕГ болон ХНХЯ-ны сайдтай байгуулсан гэрээний хэрэгжилт /2016-2021/	38
Хавсралт 4	Жижиг дунд үйлдвэрлэл, Сум хөгжүүлэх сангийн зарцуулсан төсөв, бий болсон ажлын байрны тоо /2016-2021/	39
Хавсралт 5	Аймгуудын ажиллагчдын тоо, ажилгүйчүүдийн тоо, ажиллах хүчнээс гадуурх хүн амын тоо, ажлын байрны захиалгын тоо харьцуулсан судалгаа /2016-2021/	40
Хавсралт 6	Сумдын 2016-2021 оны харьцуулсан судалгаа	
Хавсралт 7	Төрөөс хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх чиглэлээр авч хэрэгжүүлсэн төсөл, хөтөлбөрийн батлагдсан төсөв, төсвийн гүйцэтгэл	



БҮЛЭГ 1. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэхтэй холбоотой ажил хариуцсан байгууллага хоорондын уялдаа холбоо муу, хөдөлмөр эрхлэлтийн аймгийн зөвлөл дүрэмд заасан чиг үүргээ хэрэгжүүлээгүй зэргээс аймгийн бодлого төлөвлөлт хангалтгүй байна.

1.1 Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэхтэй холбоотой аймгийн бодлого, төлөвлөлт хангалтгүй, хоорондын уялдаа холбоо муу байна.

1.1.1 Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэхтэй холбоотой хэрэгжүүлсэн төсөл хөтөлбөрүүдийг аймгийн хөгжлийн бодлого төлөвлөгөөнд тусгаагүй байна.



Аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрт хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэхтэй холбоотой 6 арга хэмжээг хэрэгжүүлэхээр баталсан бол, 2016-2020 оны жил бүрийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлд нийт 12 арга хэмжээг /Он тус бүрийн заалтуудыг Хавсралт 1-ээс харна уу/ хэрэгжүүлэхээр баталсан боловч хоорондын уялдаа холбоо хангалтгүй байна.

Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгасан арга хэмжээний жил бүрийн хүрэх түвшин, шалгуур үзүүлэлт, санхүүжилтийн эх үүсвэр тодорхойгүй, хөдөлмөр эрхлэлтийн үндсэн гол үзүүлэлтүүд болох хөдөлмөр эрхлэлтийн түвшин, ажилгүйдлийн түвшин, байнгын болон түр ажлын байранд зуучлах тоо, ажиллах хүчний оролцооны түвшин зэрэгт судалгаа дүн шинжилгээ хийгээгүй байна.

Аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлд хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэхтэй холбоотой 3 арга хэмжээг хэрэгжүүлэхээр баталсан бол аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт 7 арга хэмжээг хэрэгжүүлэхээр баталсан, харин аймгийг 2021 онд хөгжүүлэх бодлого төлөвлөлтөд 9 заалт тусгагдсан байна.

Тус бодлогын баримт бичгүүдэд жил бүрийн хүрэх түвшин, шалгуур үзүүлэлт, санхүүжилтийн эх үүсвэрийг тусгасан боловч тоон мэдээлэлд дүн шинжилгээ хийж, тооцоо судалгаанд үндэслэн боловсруулаагүй байна.

Мөн ХХҮГ-аас 2016-2021 онд 7 төсөл хөтөлбөрийг жил бүр төлөвлөн хэрэгжүүлж байсан боловч аймгийн бодлогын баримт бичгүүдэд оруулж батлуулаагүй байна.

Энэ нь хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэхтэй холбоотой ажлыг хариуцсан байгууллага хоорондын уялдаа холбоо муу, урт хугацааны хөгжлийн бодлого, стратеги төлөвлөгөөг төлөвлөхдөө тооцоо судалгаанд үндэслээгүй, жил бүр хийгдэх ажлын төлөвлөгөөг нарийвчлан гаргаагүй, хэрэгжилтийн үр дүнг тооцоогүйтэй холбоотой байна.

Аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэл, Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэхтэй холбоотой зорилт арга хэмжээг ХХҮГ-аас хэрэгжүүлж буй төсөл хөтөлбөртэй уялдуулан нэмэлт өөрчлөлт оруулах шаардлагатай байна.

Мөн тооцоо судалгаа, тоон мэдээлэлд үндэслэн зорилт, шалгуур үзүүлэлтийг тогтоон, жил бүрийн хүрэх түвшин, хийгдэх ажлын төлөвлөгөөг нарийвчлан боловсруулж, хэрэгжилтэд тогтмол хяналт шалгалт хийн, үр дүнг тооцон ажиллаж байх нь зүйтэй байна.

1.2 Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх бодлогыг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг тооцоо судалгаанд үндэслэн төлөвлөөгүй байна.

ХЭДС-аас олгосон зээл, тусламжийн хэмжээг сумдад ажил хөдөлмөр эрхлээгүй иргэдийн тоотой харьцуулахад харьцангуй зөрүүтэй үр дүн гарлаа.

Хүснэгт.№3

Сумдын нэрс	Ажил хөдөлмөр эрхлээгүй нэг хүнд ногдох зээлийн дүн /Мянган төгрөг/					
	2017	2018	2019	2020	2021	Нийт
Гурвансайхан	19.0	46.5	101.5	18.1	8.6	193.8
Өндөршил	23.5	58.8	70.3	6.8	20.8	180.1
Баянжаргалан	48.8	39.2	49.5	-	35.2	172.7
Өлзийт	6.1	35.4	56.7	35.9	37.7	171.8
Дэрэн	26.7	33.6	55.0	34.8	19.8	169.8
Сайнцагаан	21.1	38.1	63.6	24.5	18.3	165.6
Дэлгэрцогт	34.5	46.2	39.3	11.0	14.7	145.7
Луус	16.9	16.3	48.0	9.2	41.5	132.0
Хулд	29.5	13.0	34.0	7.2	30.6	114.4
Дэлгэрхангай	34.5	19.4	32.8	7.6	16.6	110.9
Говь-Угтаал	17.8	15.3	37.1	20.1	18.4	108.8
Эрдэнэдалай	17.1	18.0	25.3	13.4	22.7	96.4
Адаацаг	8.7	9.9	23.4	3.3	13.5	58.7
Сайхан-Овоо	16.2	17.4	7.6	-	10.4	51.6
Цагаандэлгэр	17.2	20.7	-	-	-	37.9

*Эх сурвалж: Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар

Гурвансайхан суманд ажил хөдөлмөр эрхлээгүй нэг иргэнд ногдох зээлийн хэмжээ хамгийн өндөр буюу 0.2 сая төгрөг байхад Цагаандэлгэр суманд 0.04 сая төгрөг буюу 5.1 дахин бага төсөв хуваарилагдсан байна. Энэ нь ХЭДС-ийн төсвийн хөрөнгийг хуваарилахдаа сумдын онцлог нөхцөл байдал, хөдөлмөр эрхлэлттэй холбоотой үзүүлэлтийг харгалзан үздэггүйг харуулж байна.

Иймд төсвийг хуваарилахдаа сумдын онцлог, хүн ам, хөдөлмөр эрхлэлт, ажилгүйдлийн үзүүлэлтийг харгалзан үзэж байх шаардлагатай байна.

“Таны оршин суугаа газарт ажлын байрны олдоц хэр байна вэ?” гэсэн асуултад судалгаанд хамрагдсан 102 хүнээс 6 нь хариулаагүй, 96 хүн хамрагдаж 46 хүн буюу 45.1 хувь нь муу, 50 хүн буюу 49.0 хувь нь дунд гэж хариулсан бол сайн гэж хариулсан хүн байхгүй байна.

1.3 Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих салбарын төрийн байгууллагуудын үйл ажиллагааны уялдаа холбоо муу байна.



Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэхтэй холбоотой ХХҮГ-аас төсөл хөтөлбөрүүд хэрэгжсэнээс гадна ХХААГ жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих зээл, сумдаас Сум хөгжүүлэх сангийн зээлүүд олгож, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх үйл ажиллагаа явуулж байна.

Тухайлбал 2016-2020 онд ХХААГ-аас ЖДҮ-ийг дэмжих 1,700.4 сая төгрөгийн зээл, сумдын СХС-аас 5,215.3 сая төгрөгийн зээл тус тус олгож 1,022 ажлын байр бий болгосон гэж мэдээлсэн боловч эдгээр тоон мэдээллийг аймгийн хэмжээнд авч нэгтгэн үр дүнг тооцдоггүй, хяналт, шинжилгээ үнэлгээ хангалтгүй байна.

Мөн ажлын байр бий болгосон тоон мэдээлэл нь бодитой бус, хяналт шалгалт хийж үр дүнг тооцолгүй нийт зээл авсан төсөл хэрэгжүүлэгчийн тоогоор тайлагнасан нь ажиглагдаж байна. Сум хөгжүүлэх санд хийсэн 2016-2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар төсөл хэрэгжүүлэгч нар гэрээнд заасны дагуу үндсэн зээл, зээлийн хүүг төлөөгүй, хугацаа хэтрүүлсэн 1,519.8 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоосон нь СХС-ийн хөрөнгийн зарцуулалт үр дүн муутай байгааг илтгэж байна.

Мөн МСҮТ-өөс хөдөлмөр эрхлэлт, мэргэжил эзэмшилттэй холбоотой тоон мэдээллийг авч, дүн шинжилгээ хийдэггүй¹ Нийгмийн даатгалын хэлтэс², Улсын бүртгэлийн хэлтсээс тоон мэдээлэл авахад хүндрэлтэй, Монгол банкны мэдээллийн санд³ ХЭДС-аас олгосон зээлийн мэдээллийг оруулдаггүй зэрэг нь байгууллагын үйл ажиллагаа уялдаа холбоо муутайг харуулж байна.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэхтэй холбоотой ажил хариуцсан, төсөв зарцуулж байгаа байгууллага хоорондын уялдаа холбоог хангуулах, тоон мэдээллийг нэгтгэн, дүн шинжилгээ хийж үр дүнг тооцон ажиллаж байх шаардлагатай байна.

1.3.3 Хөдөлмөр эрхлэлтийн аймгийн зөвлөл нь хууль, дүрэмд заасан чиг үүргээ бүрэн хэрэгжүүлэхгүй байна



Аймгийн Засаг даргын захирамжаар Хөдөлмөр эрхлэлтийн аймгийн зөвлөлийг 2021 оны 02 дугаар сард 11 хүний бүрэлдэхүүнтэйгээр шинэчлэн байгуулсан байна. Зөвлөл нь Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлөөс тогтоосон дүрэмд заасан 9 төрлийн чиг үүрэг хэрэгжүүлэхээр тусгагдсан боловч хэрэгжилт хангалтгүй байна. Тухайлбал:

¹ /Бүлэг 2.3.2-ээс дэлгэрэнгүйг харна уу/

² /Бүлэг 2.1-ээс дэлгэрэнгүйг харна уу/

³ /Бүлэг 2.3.1-ээс дэлгэрэнгүйг харна уу/

- Орон нутгийн төсвөөс хөдөлмөр эрхлэлтийг дэмжих зориулалтаар зарцуулах хөрөнгийг жил бүрийн төсөвт тусган батлуулах, хөдөлмөр эрхлэлтийн талаар баримтлах бодлого, холбогдох хөтөлбөрүүд, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан, аймгийн төсвөөс санхүүжүүлэх орон нутгийн онцлогт тохирсон хөтөлбөрүүдийг боловсруулан батлуулах;
- Сангийн орлого зарлагын явц, жижиг зээлийн эргэн төлөлтөд хяналт тавих, хэрэгжсэн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр арга хэмжээний үр нөлөөнд үнэлгээ хийж санал дүгнэлт гаргах;
- Хөдөлмөр эрхлэлтийн дэмжих үйл ажиллагаанд төр хувийн хэвшлийн түншлэлийн зарчмуудыг хэрэгжүүлж, ААНБ, ТББ-ын үүсэл санаачилгыг дэмжиж, иргэдийн оролцоо ил байдлыг хангах, хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, нийлүүлэлт үр дүнгийн судалгааг мэргэжлийн байгууллагатай хамтран хийж мэдээллээр хангах;
- Хөдөлмөр эрхлэлтийн асуудлаар Төрийн захиргаа, Мэргэжлийн боловсрол, гэр бүл хүүхэд залуучуудын байгууллагууд болон бусад холбогдох байгууллагуудтай үйл ажиллагаагаа уялдуулан ажиллах;
- Орон нутагт хэрэгжсэн хөдөлмөр эрхлэлтийн талаар арга хэмжээний үр дүн болон үнэлгээний тайланг жил бүрийн эхэнд Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлд хүргүүлэх, зөвлөлийн гишүүдийн ажил үүргийн хуваарь, ард иргэдэд ажлаа тайлагнах.

Энэ нь зөвлөлийн гишүүдийн идэвх оролцоо хангалтгүйтэй холбоотой бөгөөд орон нутгийн бодлого төлөвлөлт, хөдөлмөр эрхлэлттэй холбоотой үйл ажиллагаа хариуцсан байгууллагуудыг нэгдсэн удирдлага зохион байгуулалтаар хангах, хяналт тавих ажлууд хийгдэхгүй байх, байгууллага хоорондын үйл ажиллагааны уялдаа холбоо алдагдах үр дагаврыг бий болгож байна.

Хөдөлмөр эрхлэлтийн аймгийн зөвлөл нь дүрэмд заасан чиг үүргээ хэрэгжүүлж, хөдөлмөр эрхлэлтийн бодлого, хөтөлбөр боловсруулах, түүний хэрэгжилт, үр дүнг тооцох, хөдөлмөр эрхлэлт хариуцсан байгууллагуудыг удирдлага зохион байгуулалтаар хангаж, үйл ажиллагааны уялдаа холбоог сайжруулан ажиллах шаардлагатай байна.



БҮЛЭГ 2. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажилгүйдлийг бууруулах, ажлын байрыг нэмэгдүүлэх чиглэлээр хэрэгжүүлсэн үйл ажиллагааны үр дүн, хөрөнгийн зарцуулалтын үр ашиг багатай байна.

2.1 Хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээнд хамаарах зорилтот бүлгийг тодорхойлоогүй, түүнд чиглэсэн арга хэмжээ хангалтгүй байна.

2.1.1 Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөхтэй холбоотой ажил олоход хүндрэлтэй иргэд, ажилгүйдэлд өртөж болзошгүй иргэдийн тоон мэдээлэлд дүн шинжилгээ хийхгүй байна.

Хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээний хөтөлбөрийн зорилго нь ажил олоход хүндрэлтэй иргэн болон сургууль завсардсан, хөдөлмөрийн насанд хүрсэн иргэдэд ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, ажилгүйдэлд өртөж болзошгүй иргэдийг ажил олгогчид

зуучлахад чиглэгдсэн байна. Энэ үйл ажиллагаанд тус сангаас 110.0 сая төгрөг төлөвлөж, 76.6 сая төгрөг зарцуулжээ.

2016-2021 онуудад хөтөлбөрт зарцуулсан хөрөнгө, хамрагдсан иргэдийн тоог хүснэгтээр үзүүлбэл:

Хүснэгт №4

Хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээний төрөл	Төлөвлөлт		Гүйцэтгэл		Зөрүү	
	Төлөвлөсөн зардал	Хамруулах хүний тоо	Гүйцэтгэсэн зардал	Хамруулсан хүний тоо	Зардал	Тоо
Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх, мэдээллээр хангах	77,410.10	6,135	55,010.60	4,580	22,399.50	1,555
Ажилд зуучлах үйлчилгээ	32,601.40	3,530	21,605.30	3,298	10,996.10	232
Дүн	110,011.60	9,665	76,616.00	7,629.00	33,395.60	2,036

*Эх сурвалж: Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар

Төлөвлөгдсөн сургалт, зөвлөгөө, мэдээлэл, ажлын байранд зуучлах зэрэг үйл ажиллагаанд дээрх хөрөнгийг зарцуулсан боловч ковидын нөхцөл байдлаас шалтгаалан хөдөө орон нутагт нэг бүрчлэн хүрч үйл ажиллагаа явуулж чадаагүйгээс 33.4 сая төгрөг зарцуулагдаагүй үлдсэн байна.

Хөтөлбөрийн үр дүнд 4,580 иргэн сургалт, сурталчилгаанд хамрагдаж, 3,298 иргэн ажлын байранд зуучлагдсан гэж тайлагнасан боловч ажил олоход хүндрэлтэй иргэд, сургууль завсардсан болон ажилгүйдэлд өртөж болзошгүй иргэдийн тоон мэдээллийг цуглуулж, дүн шинжилгээ хийн, сургалтын хэрэгцээ шаардлага, зорилтот бүлгийг тодорхойлох ажил хангалтгүй байна

Аудитаар хөдөлмөрийн зах зээлийн нэгдсэн системээс ажил хайгчийн мэдээллийг гаргуулан авч 2021 оны жилийн эцсийн байдлаарх ажил олоход хүндрэлтэй иргэдийн тоог ажил хайсан хугацаагаар гаргалаа. Үүнд 6 сараас 1 жилийн хугацаанд ажил хайсан 97 иргэн буюу 34.8 хувь, 3 жилээс дээш хугацаанд ажил хайсан ажил олоход хүндрэлтэй иргэд 61 буюу 26.9 хувийг эзэлж байна. Ажил олоход хүндрэлтэй иргэдийн өмнөх жилүүдийн мэдээллийг гаргаагүй байсан тул аудитаар харьцуулсан дүн шинжилгээ хийх боломжгүй байлаа. /График №1/



Аймгийн ажил эрхлээгүй иргэдээс хөдөлмөр эрхлэлттэй холбоотой санал асуулгад 16 төрлийн асуумжаар 103 иргэнийг хамруулснаас, “Та ажил хайх ямар оролдлого хийсэн бэ?” гэсэн асуултад 102 хүн оролцож, 48 хүн буюу 41.0 хувь нь ажлын зарын дагуу гэж хариулсан бол 3 хүн буюу 2.6 хувь нь боловсролын сургалтын байгууллагаар дамжуулан гэж хариулсан бөгөөд хамгийн бага хувийг эзэлж байна. Харин оролдлого хийгээгүй гэж 10 хүн буюу 8.5 хувь нь хариулсан байна.

Хүснэгт №5

Та ажил хайх ямар оролдлого хийсэн бэ?	Санал өгсөн хүний тоо	Хувь
1. Хөдөлмөрийн яармагт оролцох	15	12.8%
2. Ажлын зарын дагуу холбогдох	48	41.0%
3. Төрийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллагад ажил хайгчаар бүртгүүлэх	19	16.2%
4. Ажилд зуучлах хувийн байгууллагад ажил хайгчаар бүртгүүлэх	7	6.0%
5. Боловсрол сургалтын байгууллагаар дамжуулан	3	2.6%
6. Хувийн бизнес эхлүүлэх	15	12.8%
7. Оролдлого хийгээгүй	10	8.5%

*Эх сурвалж: Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар

“Та төрөөс хэрэгжүүлж буй ажил эрхлэлтийг нэмэгдүүлэх, дэмжих арга хэмжээний талаарх мэдээллийг хаанаас авдаг вэ?” гэсэн асуултад нийт 102 хүнээс 18 хүн хариулаагүй ба 84 хүн судалгаанд хамрагдаж, 37 хүн буюу 36.3 хувь нь баг, хорооноос мэдээлэл авдаг гэж хариулсан бол 3 хүн буюу 2.9 хувь нь мэдээлэл хангалтгүй гэж хариулсан байна. Үүнээс харахад иргэд багийн дарга, баг хорооноосоо түлхүү мэдээлэл авдаг байна.

Хүснэгт №6



№		Санал өгсөн хүний тоо	Хувь
1	Баг, хороо	37	36.3
2	Таньдаг хүнээс	15	14.7
3	ТВ, радио	11	10.8
4	Цахим орчин	18	17.6
5	Мэдээлэл хангалтгүй	3	2.9

*Эх сурвалж: Иргэдийн санал асуулга

“Таны ажил хөдөлмөр эрхлэхгүй байгаа шалтгаан юу бэ?” гэсэн асуултад судалгаанд оролцсон 102 хүнээс 11 нь хариулаагүй, 91 хүн хамрагдаж, 25 хүн буюу 24.5 хувь нь тохирох ажил олдохгүй байгаа, 14 хүн буюу 13.7 хувь нь ар гэрийн байдлаас, 12 хүн буюу 11.8 хувь нь ковид-19 цар тахлын улмаас ажлын байргүй болсон, 12 хүн буюу 11.8 хувь нь ажилд орохоор хүлээж байгаа гэж тус тус хариулсан байна.

Хүснэгт №7

Таны ажил хөдөлмөр эрхлэхгүй байгаа шалтгаан юу вэ?


Асуулт	Санал өгсөн хүний тоо	Хувь
Эрүүл мэндийн эсвэл хөгжлийн бэрхшээл	13	12.7
Ар гэрийн байдлаас	14	13.7
Боловсрол эзэмшиж байгаа	2	2.0
КОВИД-19-ийн улмаас ажлын байргүй болсон	12	11.8
Ажилд орохоор хүлээж байгаа	12	11.8
Тохирох ажил олдохгүй байгаа	25	24.5
Эзэмшсэн боловсрол ажилд нийцэхгүй байх	5	4.9
Ажлын байрны ажиллах нөхцөл муу	2	2.0
Цалин бага	4	3.9
Төрийн албаны шалгалтад хамрагдаагүй	1	1.0
Бусад (бичих)	1	1.0

*Эх сурвалж: Иргэдийн санал асуулга

2.1.2 Нэгдсэн бүртгэл, мэдээллийн системийн тоон мэдээлэл алдаатай, бодитой бус байна.

Хөдөлмөрийн зах зээлийн системийг ажил олгогч, зуучлагч талууд хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, нийлүүлэлтэд нийцүүлэн ажилгүй иргэд, зорилтот бүлгийн иргэдийг түр ба байнгын, улирлын ажлын байраар хангах зорилгоор ашигладаг. *График 2*

Гэтэл аудит хийх явцад хөдөлмөрийн зах зээлийн нэгдсэн системээс гаргуулсан тоон мэдээлэл нь зөрүүтэй, буруу гарч байгаа нь тус системийг сайжруулах шаардлагатайг харуулж байна. Тухайлбал 2019-2021 онуудад ажил хайгчийн тоо ажилд зуучилсан тооноос бага байна.



Мөн тухайн иргэний ажилд орсон, гарсан хөдөлгөөний мэдээлэл тодорхой гардаггүй, мэргэжлийн ангилал тодорхой бус зэрэг дутагдалтай тал ажиглагдлаа.

Иймд тус системийн дээрх алдаа, дутагдлыг арилгаж, сайжруулалт хийх Улсын бүртгэлийн хэлтэс, Татварын хэлтэс, Нийгмийн даатгалын хэлтэс зэрэг төрийн байгууллагуудын мэдээллийн сантай холбох, ажил хайгч иргэн болон ажил олгогчид мэдээллийг шууд харах зэргээр сайжруулалт хийх шаардлагатай байна.

Хөдөлмөрийн зах зээлийн системд ажил хайгчаар бүртгүүлсэн иргэн нь 3 сарын дотор ажил олсон эсвэл ажил үргэлжлүүлэн хайх талаар эргэж бүртгүүлэхгүй тохиолдолд системд автоматаар идэвхгүй горимд шилждэг байна. Аудитаар ажил хайгчаар бүртгүүлсэн ч эргэж ажилд орсон ороогүй талаар мэдээлээгүй, системд идэвхгүй байгаа иргэдийн тоог гаргуулахад 2016-2018 онуудад 424 иргэн буюу нийт ажил хайгчийн 16.7 хувь, 2019-2021 онуудад 224 иргэн буюу нийт ажил хайгчдын 16.6 хувийг эзэлж байна. Энэ нь ажил хайгчийн идэвхгүй байдлаас шалтгаалж байгаа бөгөөд хүмүүсийн хандлага, идэвх оролцоог нэмэгдүүлэх сургалт сурталчилгаа хийх шаардлагатайг харуулж байна. /График 2/

Иймд ажил олоход хүндрэлтэй, идэвхгүй ажил хайгч иргэдийн тоон мэдээллийг цуглуулж, дүн шинжилгээ хийн эдгээр хүмүүст чиглэсэн ажил мэргэжлийн чиг баримжаа олгох сургалт зохион байгуулж, үр дүнг тооцон ажиллах шаардлагатай байна.

2.2 Аймгаас хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажилгүйдлийг бууруулах, ажлын байр нэмэгдүүлэх чиглэлээр хэрэгжүүлсэн арга хэмжээг сайжруулах шаардлагатай байна.


2.2.1 Төсөл, хөтөлбөрийн хэрэгжилт үр дүнг бодитой тооцож үнэлээгүй, төсвийн зарцуулалт үр дүн багатай байна

График 3

ХХҮГ нь 2016-2021 оны хооронд 3,662.5 сая төгрөгийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих 5 арга хэмжээ хэрэгжүүлэн ажилласан ба үүний 341.6 сая төгрөг нь буцалтгүй тусламж, 172.1 сая төгрөг нь 50 хувь нь эргэн төлөгдөх зээл, 1,750.0 сая төгрөг нь 100 хувь эргэн төлөгдөх зээл, 76.0 сая төгрөг нь аж ахуйн нэгжид олгосон урамшуулал, 1,322.8 сая төгрөг нь сургалт, сурталчилгаа, үйл ажиллагааны бусад зардал эзэлж байна. /График 3/



График 4




Аудитаар ХЭДС-аас 2016-2021 онд сумдад олгосон зээл, тусламжийн дүнг тухайн онуудын хөдөлмөр эрхлэлт, ажилгүйдэлтэй холбоотой тоон мэдээлэлтэй харьцуулалт хийлээ.

Ажилгүйдлийн түвшин улсын дунджаас доогуур, хөдөлмөр эрхлэлтийн түвшин, ажиллах хүчний оролцооны түвшин улсын дунджаас дээгүүр үзүүлэлттэй байгаа хэдий ч 2021 онд эдгээр

үзүүлэлтүүд өмнөх оноос буурсан үзүүлэлттэй байна.

Хөдөлмөр эрхлэлтийн түвшин, ажилгүйдлийн түвшнийг төвийн бүсийн 4 аймагтай харьцуулан үзлээ. /График 4/

График 5



Дундговь аймгийн хөдөлмөр эрхлэлтийн түвшин 2016-2018 онд Төв аймгаас бусад аймгаас өндөр үзүүлэлттэй гарсан бол 2019, 2020 онд хамгийн өндөр үзүүлэлттэй гарсан байна. /График 5/

График 6



Ажилгүйдлийн түвшин 2016-2020 онд Төв аймаг хамгийн бага үзүүлэлттэй гарсан бол Дундговь аймаг бусад аймгаас харьцангуй бага үзүүлэлттэй байна.

ХЭДС-аас зарцуулсан төсөв,

ажилгүйдлийн түвшин, хөдөлмөр эрхлэлтийн түвшин, ажиллах хүчний оролцооны түвшин хоорондын хамаарлын шинжилгээ хийхэд хамаарлын хүч нь дунд, болон бага гарсан. Өөрөөр хэлбэл 2016-2021 онд ХЭДС-аас зарцуулсан төсөв нь хөдөлмөр эрхлэлтийн түвшин, ажиллах хүчний оролцооны түвшнийг нэмэгдүүлэхэд бага зэрэг нөлөөлсөн бол ажилгүйдлийн түвшнийг бууруулахад нөлөөлөөгүй үр дүн гарсан.

ХЭДС-аас сумдад 2016-2021 онд хуваарилсан төсвийн зарцуулалт болон сумдын тухайн он бүрийн ажиллах хүчний оролцооны түвшин хоорондын хамаарлыг авч үзэхэд эерэг маш хүчтэй хамааралтай буюу төсвийн зарцуулалт үр дүнтэй 3 сум, дунд зэрэг хамааралтай 2 сум, сул хамааралтай 1 сум, хамааралгүй 5 сум байгаа бол бусад 4 сум сөрөг хамааралтай буюу төсвийн зарцуулалт үр дүн муутай гэсэн үр дүн гарлаа.

Энэ нь ХЭДС-аас зарцуулсан хөрөнгө болон сумдад хуваарилагдсан төсвийн зарцуулалт үр дүн муутай байгааг харуулж болохоор байна. /График 6/

Иймд төсөл хөтөлбөр, төсвийг сумд, бүс нутгийн онцлог шинж чанар, хүн ам, хөдөлмөр эрхлэлттэй холбоотой үзүүлэлтүүдийг харгалзан үзэж, тооцоо судалгаанд үндэслэн хуваарилж байх шаардлагатай байна.

2.2.2 Төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтийг тайлагнаж, үнэлсэн боловч үр дүнг бодитой тооцоогүй байна.

Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын хэлтсээс Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрт хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэхтэй холбоотой бүх заалтуудыг 100 хувь гэж үнэлсэн байна.

Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хөдөлмөр эрхлэлттэй холбоотой заалтуудын жил бүрийн хүрэх түвшин, шалгуур үзүүлэлт тодорхойгүй байхад хэрэгжилтийг 100 хувь гэж үнэлсэн нь бодитой бус, учир дутагдалтай байна.

Аймгийн Засаг даргын Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайдтай 2016-2021 онд байгуулсан гэрээнд хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэхтэй холбоотой 7 заалт байгаа бол аймгийн ХХҮГ-ын даргын 2016-2021 онд Хөдөлмөр, халамж үйлчилгээний ерөнхий газрын даргатай байгуулсан гэрээнд хөдөлмөр, нийгмийн

хамгааллын чиглэлээр нийт 22 заалт тусгагдсанаас хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэхтэй холбоотой 6 заалт байна.

Гэрээний хэрэгжилт 5 жилийн дундаж үнэлгээгээр Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдтай байгуулсан гэрээ 93.5 хувьтай дүгнэгдсэн бол Хөдөлмөр, нийгмийн хамгааллын Ерөнхий газартай байгуулсан гэрээ 94 хувиар үнэлэгдсэн байна. /Жил бүрийн үнэлгээг Хавсралт 3-аас харна уу/. ХХҮГ-ын ерөнхий газартайгаа байгуулсан гэрээнд жил бүр хэрэгжүүлэх төсөл хөтөлбөрийг тусган, хэрэгжилтийг үнэлүүлдэг ба төсөл хөтөлбөрийг тус бүрийг тусгайлан үнэлж, үр дүнг тооцон ажиллаагүй байна.

2.2.3 Эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих талаар бодлогын баримт бичигт тусгаагүй ч оролцооны түвшин эрэгтэй хүмүүстэй ойролцоо байна.

Аймгийн бодлогын баримт бичгүүдэд эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих талаар огт тусгаагүй боловч хөдөлмөрийн насны эрэгтэй, эмэгтэй хүмүүс болон ажиллагч эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн харьцаа ойролцоо байлаа.

Хүснэгт №8

Үзүүлэлт	2016 он	2017 он	2018 он	2019 он	2020 он	2021 он
Хөдөлмөрийн насны эрэгтэй	16,144	16,349	16,366	16,101	16,314	16,349
Ажиллагч эрэгтэй	10,522	11,532	11,571	11,530	10,811	10,658
Эзлэх хувь	65.2	70.5	70.7	71.6	66.3	65.2
Ажиллагч эрэгтэй	16,255	16,576	16,531	16,215	16,444	16,576
Ажиллагч эмэгтэй	10,589	11,088	11,757	10,510	10,652	10,877
Эзлэх хувь	65.1	66.9	71.1	64.8	64.8	65.6

*Эх сурвалж: 1212.mn

Энэ нь эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн хөдөлмөр эрхлэлтийн харьцаа адилхан байгааг харуулж байна.

“Та орон нутгийнхаа ажилгүй иргэдийн бүртгэлд бүртгүүлсэн үү?” гэсэн асуултад 28 эрэгтэй хамрагдсанаас 16 нь буюу 57.1 хувь нь бүртгүүлсэн гэж хариулсан бол, судалгаанд хамрагдсан 52 эмэгтэйдээс 25 нь буюу 48.1 хувь нь бүртгүүлсэн гэж хариулсан байна.

2.3 Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн хөрөнгийг бүрэн төвлөрүүлээгүй, сангийн хөрөнгийг хуулийн дагуу зарцуулсан ч үр нөлөөг тооцон ажиллаагүй байна.

2.3.1 Төсөл хэрэгжүүлэгч нарт олгосон зээлийн эргэн төлөлт хангалтгүй, хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг ажиллуулаагүйн төлбөрийг бүрэн төвлөрүүлээгүй байна.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн орлого нь улсын төсвийн хөрөнгө, олон улсын байгууллагын зээл тусламж, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг ажиллуулаагүйн төлбөрийн орлого болон бусад эх үүсвэрээс бүрддэг байна. ХХҮЕГ-аас сангийн эх үүсвэрийг 2016-2021 онуудад нийт 3,851.4 сая төгрөгөөр төлөвлөсөн ч гүйцэтгэлээр 3,787.7 сая төгрөгийн санхүүжилт авчээ.

Хүснэгт №9

		2016 он	2017 он	2018 он	2019 он	2020 он	2021 он	Дүн
Үндсэн санхүүжилт /мян.төг/	Төлөвлөгөө	638,898.5	644,350.0	683,500.0	964,000.0	381,635.1	484,746.2	3,797,129.8
	Гүйцэтгэл	643,000.0	584,594.5	683,500.0	964,000.0	370,000.0	454,548.2	3,699,642.7
	Төлөвлөгөө						54,249.2	54,249.2

Гадаад улс, олон улсын байгууллагын зээл, тусламж /мян.төг/	Гүйцэтгэл					49,359.0	38,728.8	88,087.8
ХБИ ажиллуулаагүйн төлбөрийн орлого /мян.төг/	Төлөвлөгөө		8,000.0		2,000.0	3,000.0	3,000.0	16,000.0
	Гүйцэтгэл		2,592.0	3,456.0	6,528.0	864.0	13,256.5	26,696.5
Нийт	Төлөвлөгөө	638,898.5	652,350.0	683,500.0	966,000.0	384,635.1	541,995.4	3,867,379.0
	Гүйцэтгэл	643,000.0	587,186.5	686,956.0	970,528.0	420,223.0	506,533.5	3,814,427.0

*Эх сурвалж: Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар

Батлагдсан төлөвлөгөөг бүрэн зарцуулсан ч 2017, 2021 онуудад санхүүжилт дутуу авсан нь жилийн эцэст санхүүжилт орж ирснээс тайлант ондоо багтаан зарцуулалт хийж амжилгүй буцаан төвлөрүүлсэнтэй холбоотой байна.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг ажиллуулаагүйн төлбөрийг бүрэн төвлөрүүлж чадаагүй байна

ХБИ ажиллуулаагүйн төлбөрийн орлогыг 2016-2021 онуудад 16.0 сая төгрөг төвлөрүүлэхээр төлөвлөж гүйцэтгэлээр 26.7 сая төгрөгийг төвлөрүүлсэн байна. Батлагдсан орлогын төлөвлөгөөг давуулан биелүүлсэн боловч аймгийн хэмжээнд 14 ААНБ-аас ХБИ ажиллуулаагүйн төлбөр авахаас зөвхөн 4 байгууллагаас төлбөр авчээ.

Мөн ХХҮГ-аас гаргасан 25 ба түүнээс дээш ажилтантай ААНБ-ын тооны судалгааг Нийгмийн даатгалын хэлтсээс ирүүлсэн судалгаатай харьцуулахад мэдээлэл зөрүүтэй байлаа.

Эдгээр асуудал нь хөдөлмөр эрхлэлт хариуцсан ажилтан нь улсын байцаагчийн эрхгүйгээс ААНБ-д шаардлага тавих, шаардлагатай мэдээлэл авахад хүндрэлтэй байдаг, мөн байгууллага хоорондын үйл ажиллагаа уялдаа холбоо муу байгаатай холбоотой байна.

Засгийн газрын 2009 оны 26 дугаар тогтоолыг үндэслэн ХБИ ажиллуулаагүйн төлбөрийг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний 30 хувиар тогтоож тооцдог байсныг 2019 оны 111 дүгээр тогтоолоор хүчингүй болгож, 25 ба түүнээс дээш ажилтантай ААНБ нийт ажлын байрныхаа дөрвөн хувиас доошгүй орон тоонд хөгжлийн бэрхшээлтэй иргэн ажиллуулаагүйн төлбөрийн хэмжээг тухайн байгууллагад ажиллагчдын дундаж цалингийн 60 хувь байхаар шинэчлэн тогтоосон боловч шинэчлэн тогтоосон тооцооллыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Иймд 25 ба түүнээс дээш ажилтантай ААНБ-аас хөгжлийн бэрхшээлтэй хүнийг ажиллуулаагүйн төлбөрийг Хөдөлмөрийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн 144 дүгээр зүйлийн 144.2⁴, 144.3⁵-т заасны дагуу ХЭДС-ийн дансанд төвлөрүүлэх ажлыг хэрэгжүүлэн ажиллах талаар ХХҮГ-т албан шаардлага хүргүүлээ.

ХХҮГ-ын хөдөлмөр хариуцсан албан хаагчид хөдөлмөр эрхлэлттэй холбоотой мэдээллийг холбогдох байгууллагаас авах, шаардлага тавих, түүнийг хэрэгжүүлээгүй тохиолдолд хариуцлага хүлээлгэдэг эрхтэй байх эрх зүйн зохицуулалтыг холбогдох хууль, журамд тусгах шаардлагатай байна.

⁴ 144.2.Өмчийн төрөл, хэлбэрээс үл хамаарч 25 ба түүнээс дээш ажилтантай аж ахуйн нэгж, байгууллага нийт ажлын байрныхаа дөрвөн хувиас доошгүй орон тоонд хөгжлийн бэрхшээлтэй хүнийг ажиллуулна.

⁵ 144.3.Аж ахуйн нэгж, байгууллага энэ хуулийн 144.2-т зааснаар хөгжлийн бэрхшээлтэй хүн ажиллуулаагүй бол ажиллуулбал зохих орон тоо тутамд ногдох төлбөрийн хэмжээ нь хөдөлмөрийн хөлсний доод хэмжээтэй тэнцүү байх бөгөөд уг төлбөрийг сар бүр Хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих дэд санд төлнө.

Зээлийн эргэн төлөлт хангалтгүйгээс сангийн эх үүсвэрийг гэрээнд заасан хугацаанд бүрэн төвлөрүүлэхгүй байна.

2016-2021 онуудад хөдөлмөр эрхлэлтийг дэмжих 5 арга хэмжээнд нийт 2,094.1 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэг олгож, 1,194.2 сая төгрөгийг хөдөлмөр эрхлэлтийг дэмжих санд буцаан төвлөрүүлжээ.

Санхүүгийн дэмжлэгийн эргэн төлөлтийн хувьд 2021 оны жилийн эцсийн байдлаар 220.8 сая төгрөгийн зээл хугацаа хэтрэлттэй буюу зээлийн эргэн төлөлт хангалтгүй байна. Энэ нь нийт зээлийн үлдэгдэл 988.2 сая төгрөгийн 22.3 хувийг эзэлж байна.

Санхүүгийн дэмжлэгийн эргэн төлөлт хангалтгүй байгаа нь төсөл хэрэгжүүлэгчдэд олгосон зээлийн хэмжээ хангалтгүй, санхүү, бизнесийн удирдлага, төлөвлөлтийн мэдлэг хомсоос шалтгаалан төсөл амжилтгүй болж, зээлийн эргэн төлөлт хийгдэхгүй байна. Мөн Монгол банкны мэдээллийн санд зээлдэгчийн мэдээлэл бүртгэгддэггүй, зээлийг эргэн төлөхгүй тохиолдолд хүлээлгэх хариуцлагын зохицуулалт байхгүй нь зээл эргэн төлөлт хангалтгүй байгаад нөлөөлж байна.

Иймд хугацаа хэтрэлттэй зээлийг төсөл хэрэгжүүлэгч нараар нөхөн төлүүлж сангийн эх үүсвэрийг бий болгох, төсөл хэрэгжүүлэгч нарт санхүүгийн мэдлэг олгох, бизнес эрхлэх талаар сургалт сурталчилгаа явуулж, төслийг амжилттай хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэн ажиллах шаардлагатай байна.

Төсөл хэрэгжүүлэгч нарт олгож байгаа санхүүгийн дэмжлэгийн хэмжээг үйл ажиллагаагаа өргөжүүлэх, амжилттай хэрэгжүүлэхэд хүрэлцэхүйц хэмжээний зээлийг төслийн онцлогт тохируулан олгох, хугацаа хэтэрсэн зээлдэгчийн мэдээллийг монгол банкны чанаргүй зээлийн мэдээллийн санд оруулдаг болох шаардлагатай байна.

2.3.2 ХЭДС-ийн хөрөнгийг хууль, журмын дагуу зарцуулсан боловч, үр нөлөөг тооцон ажиллахгүй байна.

Аймгийн хэмжээнд 2016-2021 онуудад нийт 6 төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэх 3,416.8 сая төгрөгийн төсөв батлагдаж гүйцэтгэлээр 3,138.6 сая төгрөгийн зарцуулжээ. Хөтөлбөр тус бүрээр төсвийн зарцуулалт, хэрэгжилтийг авч үзлээ.

Ажлын байрыг дэмжих хөтөлбөр:

Хувиараа болон нөхөрлөл, хоршооны хэлбэрээр аж ахуйн, бичил бизнес эрхлэн үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчийг санхүүгийн болон бусад дэмжлэг, арга хэмжээнд хамруулж, байнгын ажлын байр бий болгох, ажил олгогчид урамшуулал олгох, ажлын байрыг хадгалах, ажил хайгч, оюутан, мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагад суралцагчийг түр ажлын байраар хангаж, орлого нэмэгдүүлэх зорилгын хүрээнд ажлын байрыг дэмжих хөтөлбөрөөс 2016-2021 онд 1,304.6 сая төгрөгийг зарцуулжээ.

Хүснэгт №10

Арга хэмжээний төрөл	Төлөвлөсөн зардал	Гүйцэтгэсэн зардал	Зөрүү
Санхүүгийн дэмжлэг	740,600.0	700,600.0	40,000.0
Ажил олгогчийн урамшуулал	73,416.0	55,320.0	18,096.0
Сургалт, бусад арга хэмжээ	630,890.0	548,660.4	82,229.6
Дүн	1,444,906.0	1,304,580.4	140,325.6

*Эх сурвалж: Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар

Тус хөтөлбөрийн хүрээнд 700.6 сая төгрөгийг эргэн төлөгдөх нөхцөлтэй санхүүгийн дэмжлэгт, 55.3 сая төгрөгийг ажилгүй иргэнийг ажлын байраар хангасан 15 ажил олгогчид урамшуулал болгон олгосон байна.

Ажил олгогчид олгосон урамшууллыг Нийгмийн даатгалын хэлтсээс тухайн ажлын байраар хангагдсан ажилтны нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн талаарх тодорхойлолтыг авч тулгахад зөрчилтэй асуудал гараагүй.

Санхүүгийн дэмжлэг авсан төсөл хэрэгжүүлэгч нарын үйл ажиллагаанд түүвэрчлэн хяналт хийх явцад Эрдэнэдалай сумын 1 төсөл хэрэгжүүлэгч 5.0 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэгийг зориулалт бусаар зарцуулсан, үйл ажиллагаа явуулаагүй байсныг илрүүлж, зээлийн эргэн төлөгдөх хугацаа хэтэрсэн 17 зээлдэгчийн 59.8 сая төгрөгийг сангийн дансанд буцаан төлүүлэх төлбөрийн акт тогтоов.

Орон нутгийн онцлогтой зорилтот хөтөлбөр:

Орон нутгийн онцлог хэрэгцээнд нийцүүлсэн зорилтот төсөл 2019 онд хэрэгжсэн бөгөөд төсөл сонгон шалгаруулалт зохион байгуулж 20 төслөөс 4 төслийг шалгаруулж 59.9 сая төгрөгийн зээлийг олгожээ. Тус 4 төсөл хэрэгжүүлэгч нараас 3 нь төсвийг зориулалт бусаар зарцуулсан, үйл ажиллагаа явуулаагүй, 1 төсөл хэрэгжүүлэгч нь үйл ажиллагаа явуулж байгаа боловч зээлийн эргэн төлөлт хугацаа хэтрэлттэй байна.

Иймд 3 төсөл хэрэгжүүлэгчид олгосон 39.9 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэгийг зориулалт бусаар зарцуулсан гэж үзэн сангийн дансанд буцаан төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоосон.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрыг дэмжих хөтөлбөр:



ХБИ-ийг хөдөлмөрт бэлтгэх, ажилд зуучлах, тэдний аж ахуй эрхлэлт болон хөдөлмөр эрхлэх ур чадвар олгох сургалт, арга хэмжээнд 2016-2021 онд 36.0 сая төгрөг, ХБИ-ийг ажлын байраар хангасан ААНБ-д 26.1 сая төгрөгийн урамшуулал, ХБИ-д зориулсан байнгын ажлын байрыг нэмэгдүүлэх зорилгоор 55.0 сая төгрөгийн буцалтгүй тусламж, 194.1 сая төгрөгийн эргэн төлөгдөх нөхцөлтэй зээл олгожээ.

Хүснэгт №11

Төрөл	Төлөвлөсөн зардал	Гүйцэтгэсэн зардал	Зөрүү
100 хувь буцалтгүй	55,000.0	55,000.0	-
50 хувь эргэн төлөгдөх	94,100.0	94,100.0	-
100 хувь эргэн төлөгдөх	100,000.0	100,000.0	-
Ажил олгогчийн урамшуулал	35,220.0	26,148.0	9,072.0
Сургалт, бусад арга хэмжээ	73,298.0	36,008.4	37,289.6
Нийт	357,618.0	311,256.4	46,361.6

*Эх сурвалж: Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар

Аудитаар ХБИ ажиллуулж урамшуулал авсан ажил олгогчдын ажлын байраар хангагдсан хөгжлийн бэрхшээлтэй ажилтны нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн талаарх

тодорхойлолтыг аймгийн Нийгмийн даатгалын хэлтсээс авч тулгалт хийхэд 2019 онд Улаанбаатар хот руу шилжсэн иргэнийг ажлын байраар хангасан гэж 2020 онд “Булаг Ундрах” ХХК-тай “Хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг ажлын байраар хангасан ажил олгогчид урамшуулал олгох” гэрээ байгуулан 4.1 сая төгрөг олгосон бол бусад урамшуулалд зөрчилтэй асуудал гараагүй.

Шаардлага хангаагүй ААНБ-д олгосон урамшууллыг улсын төсөвт нөхөн төлүүлэхээр ХХҮЕГ-ын улсын байцаагч төлбөрийн акт тогтоосон байна. Мөн зээлийн эргэн төлөгдөх хугацаа хэтэрсэн 1 зээлдэгчийн 1.5 сая төгрөгийг сангийн дансанд буцаан төлүүлэх төлбөрийн акт тогтоов.

Малчны хөдөлмөр эрхлэлтийг дэмжих:

Залуу малчин, цөөн малтай иргэдэд мал маллагааны арга ажиллагааны болон аж ахуй эрхлэх ур чадвар олгох, малжуулах арга хэмжээг хэрэгжүүлж өрхийн орлогыг нэмэгдүүлэх зорилгоор 2016-2021 онд 65.2 сая төгрөгийн сургалт, арга хэмжээг зохион байгуулж, 50 хувь эргэн төлөгдөх нөхцөлтэй 225.0 сая төгрөг, 100 хувь эргэн төлөгдөх нөхцөлтэй 649.0 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэгийг олгожээ.

Хүснэгт №12

Санхүүгийн дэмжлэгийн төрөл	Төлөвлөсөн зардал	Гүйцэтгэсэн зардал	Зөрүү
50 хувь эргэн төлөгдөх	225,000.0	225,000.0	-
100 хувь эргэн төлөгдөх	674,000.0	649,000.0	25,000.0
Сургалт, бусад арга хэмжээ	84,110.0	65,231.4	18,878.6
Нийт	983,110.0	939,231.4	43,878.6

*Эх сурвалж: Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар

Аймгийн хэмжээнд хэрэгжсэн 6 төсөл хөтөлбөрт нийт 2,094.1 сая төгрөгийн зээл олгогдсоноос 41.7 хувь буюу 874.0 сая төгрөгийн зээлийг 195 малчин өрхөд олгосон байна. 2021 оны жилийн эцсийн байдлаар 287.4 сая төгрөгийн зээлийн үлдэгдэл байгаагаас 10 зээлдэгчийн 15.3 сая төгрөгийн зээл хугацаа хэтрэлттэй байгаа тул сангийн дансанд буцаан төлүүлэх төлбөрийн акт тогтоов.

Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих зээлийн сумдад олгогдсон дүнг ихээс бага руу эрэмбэлэн дугаарлаж, сумдын хөдөлмөрийн насны нэг хүнд ногдох малын тоог багаас их рүү эрэмбэлэн дугаарлаж харьцуулалт хийлээ.



Сайхан-Овоо, Луус сумдын хөдөлмөрийн насны нэг хүнд ногдох малын тоо бусад сумдтай харьцуулахад бага боловч олгосон зээлийн хэмжээ бага харин Өлзийт, Гурвансайхан сумдын малын тоо харьцангуй өндөр боловч олгосон зээлийн хэмжээ өндөр байгаа нь зээлийн хуваарилалт оновчтой бус байгааг харуулж болохоор байна. /График 7/

Залуучуудын хөдөлмөр эрхлэлт, гарааны бизнесийг дэмжих хөтөлбөр:

Залуучуудад хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээ үзүүлэх болон аж ахуй эрхлэх өөрөө өөртөө ажлын байр бий болгох, бүтээлч, шинэлэг санал, санаачилгыг дэмжихэд зориулж 2016-2021 онд 314.0 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэг олгож, 75.2 сая төгрөгийг сургалтын арга хэмжээнд зарцуулсан байна.

Хүснэгт №13

Санхүүгийн дэмжлэгийн төрөл	Төлөвлөсөн зардал	Гүйцэтгэсэн зардал	Зөрүү
Санхүүгийн дэмжлэг	336,000.0	314,000.0	22,000.0
Сургалт, бусад арга хэмжээ	86,420.0	75,190.7	11,229.3
Нийт	422,420.0	389,190.7	33,229.3

*Эх сурвалж: Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар

Санхүүгийн дэмжлэгийн хэрэгжилтэд хяналт хийх явцад Эрдэнэдалай сумын 1 төсөл хэрэгжүүлэгч 10.0 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэгийг зориулалт бусаар зарцуулсан, үйл ажиллагаа явуулаагүй байсныг илрүүлж, зээлийн үлдэгдэл 8.8 сая төгрөгийг сангийн дансанд буцаан төлүүлэх төлбөрийн акт тогтоов.

Аудитаар 15-34 насны хүн амд тухайн насны ажиллагчдын тооны эзлэх хувийн жин болон залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжихэд зарцуулсан төсөв хоорондын хамаарлын шинжилгээ хийлээ. Шинжилгээний үр дүнд хамаарлын хүч нь **(-0.99)** буюу сөрөг маш хүчтэй хамааралтай гарсан ба энэ нь залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжихтэй холбоотой зарцуулсан төсөв нь үр дүн муутай гэж дүгнэж болохоор байна.

Хүснэгт №14

Насны ангилал	Үзүүлэлт	2016	2017	2018	2019	2020	2021
---------------	----------	------	------	------	------	------	------

15-34 насны	Ажиллагчдын тоо	6,784	7,910	7,565	5,418	7,358	6,952
	Хүн ам	15,379	15,431	15,077	14,301	14,308	14,029
	Ажиллагчдын хүн амд эзлэх хувь	44.1	51.3	50.2	37.9	51.4	49.6
	Зарцуулсан төсөв /мянган төгрөг/		38,000.0	44,000.0	140,000.0	40,000.0	

*Эх сурвалж: Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар

САЙН ТУРШЛАГА:

Залуучуудын аж ахуйн бизнес эрхлэх ур чадвар шинэлэг санаанд тулгуурлан санхүүгийн дэмжлэг олгох "Гарааны бизнесээ эхлэх START-UP" арга хэмжээ 2017 онд туршилтаар 9 дүүрэг 4 аймагт хэрэгжсэний нэг нь Дундговь аймаг байсан байна. Тус арга хэмжээнд 50 гаруй залуучууд өрсөлдөж "Загсгалтай цай" төсөл хэрэгжүүлэхээр Сайнцагаан сумын 1 иргэн шалгарч бүтээгдэхүүнээ одоог хүртэл үйлдвэрлэн зах зээлд борлуулж байна.

Мөн 2021 онд нийт 16 багийн 50 гаруй залуучууд өрсөлдсөнөөр 8 баг 2-р шатанд шалгарч эцсийн шатанд WIMELO баг хүний биеийн онцлогт тохирсон захиалгат хувцас үйлдвэрлэлийн чиглэлээр шалгарч 10.0 сая төгрөгийн санхүүжилтийг эргэн төлөх нөхцөлгүйгээр олгосон. Энэхүү баг нь 21 аймаг 9 дүүргийн шилдэг START-UP арга хэмжээнд оролцон шилдэг 10 багийн 1-ээр шалгарсан.

Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээг хөгжүүлэх хөтөлбөр:

Ахмад мэргэжилтнүүдийн хүсэлтэд үндэслэн ажил, хөдөлмөрт оролцох оролцоог нэмэгдүүлж, мэдээллийн сан үүсгэн, тэдний мэдлэг, ажлын туршлагыг өвлүүлэх, зөвлөн туслах үйлчилгээ үзүүлэх өсвөр хойч залуу үеийнхэнд хөдөлмөрийн дадал олгох чиглэлээр ажиллуулж орлогын дэмжлэг үзүүлэх зорилгоор 2016-2021 онд санхүүгийн дэмжлэгт 93.0 сая төгрөг, сургалт сурталчилгаа бусад арга хэмжээнд 41.3 сая төгрөг зарцуулжээ.

Хүснэгт №15

Санхүүгийн дэмжлэгийн төрөл	Төлөвлөсөн зардал	Гүйцэтгэсэн зардал	Зөрүү
Санхүүгийн дэмжлэг	93,000.0	93,000.0	-
Сургалт, бусад арга хэмжээ	55,786.5	41,345.5	14,441.0
Нийт	148,786.5	134,345.5	14,441.0

*Эх сурвалж: Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар



Аймгийн хэмжээнд 31 ахмадад нийт 93.0 сая төгрөгийн зээл олгосноос 2021 оны жилийн эцсийн байдлаар 41.7 сая төгрөгийн үлдэгдэлтэй байгаа бөгөөд 13.5 сая төгрөгийн зээл эргэн төлөгдөөгүй хугацаа хэтрэлттэй байна. Хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдлийг сангийн дансанд буцаан төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоов.

Мэргэжлийн боловсрол сургалтын талаар:

Аймгийн МСҮТ-ийн 2016-2021 оны нийт төсөв 9,869.6 сая төгрөгөөр батлагдсанаас 9,606.7 сая төгрөгийг гүйцэтгэлээр зарцуулж, нийт 1652 төгсөгч суралцан төгссөнөөс 1241 сурагч буюу 75.1 хувь нь ажлын байраар хангагдаж, 24 сурагч буюу 1.4 хувь нь Улаанбаатар болон бусад газарт мэргэжил дээшлүүлэхээр суралцсан бол 382 төгсөгч буюу 23.1 хувь нь тодорхой ажил эрхлээгүй байна гэж тайлагнажээ. /Хавсралт 2 /

МСҮТ-ийн сургалтын албанаас суралцагчдын тоо, ажлын байраар хангагдсан төгсөгчдийн мэдээлэлд тандалт судалгаа хийж бүртгэлжүүлэн авдаг боловч аймгийн хэмжээнд тоон

мэдээллийг авч, нэгтгэн дүгнэдэггүй, хөдөлмөр эрхлэлтийн бодлого, төсөл хөтөлбөртэй уялдуулан төлөвлөхгүй байна.

2.4 "Ковид-19" цар тахлын үед хөдөлмөр эрхлэлтийн талаар төрөөс авч хэрэгжүүлсэн арга хэмжээ нь санхүү, үйл ажиллагааны хүндрэлд орсон ААНБ, хувиараа хөдөлмөр эрхлэгчид чиглэгдэж чадаагүй байна.

Монгол Улсын Засгийн газраас хэрэгжүүлсэн “Эрүүл мэндээ хамгаалж эдийн засгаа сэргээх 10 их наяд цогц төлөвлөгөө”-ний хүрээнд ажлын байрыг дэмжих гурван хувийн хүүтэй зээлийг аймгийн хэмжээнд арилжааны 3 банкаар дамжуулан малчдыг дэмжих чиглэлээр 1,141 өрхөд 11,632.4 сая төгрөг, бизнес эрхлэлтийг дэмжих чиглэлээр 303 иргэн, ААНБ-д 15,760.3 сая төгрөг, нийт 27,392.7 сая төгрөгийн зээлийг олгожээ.

Хүснэгт №16

д/д	Банкны нэр	Зээлийн ангилал		Олгогдсон нийт зээл	Засгийн газраас төлөх хүү
		Малчдыг	Бизнесийг		
1	ХААН банк	7,411,600.0	6,386,957.0	13,798,557.0	1,722,941.4
2	Төрийн банк	4,220,800.0	8,389,828.0	12,610,628.0	1,483,447.1
3	Хас банк		983,500.0	983,500.0	111,744.5
	Дүн	11,632,400.0	15,760,285.0	27,392,685.0	3,318,133.1

*Эх сурвалж: Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар

Арилжааны банкнууд тус зээлийг өөрийн чөлөөт эх үүсвэрээсээ олгосон бөгөөд Засгийн газраас 2021 оны 02 сарын 17-ны өдрийн 42 дугаар тогтоолоор аж ахуйн нэгжид олгосон зээлийн нийт хүүгийн 6 хувийг, иргэнд олгосон зээлийн нийт хүүгийн 7 хувь буюу аймгийн хэмжээнд нийт 3,318.1 сая төгрөгийг төрөөс хариуцахаар болсон байна.

Дээрх зээлийг зөвхөн банкны зээлийн үйл ажиллагааны журам, зааврын хүрээнд тавигдсан шаардлагыг хангасан, үйлдвэрлэл, үйлчилгээ, худалдаа эрхлэгч ААНБ, хувь хүн, малчин өрхөд олгосон байна. Арилжааны банкнууд хөдөлмөр эрхлэлт хариуцсан байгууллага, албан тушаалтныг оролцуулж санал аваагүй, хамтран ажиллаагүй, зөвхөн өөрийн шалгуурт нийцүүлэн олгосон нь Ковид-19 цар тахлын үеийн хүндрэлд орсон ААНБ, хувиараа хөдөлмөр эрхлэгч нарт чиглэгдээгүй гэж дүгнэхээр байна.



Дүгнэлт

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлт хийж байна. Үүнд:

- Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байр нэмэгдүүлэхтэй холбоотой ажил хариуцсан байгууллага хоорондын уялдаа холбоо муу, хөдөлмөр эрхлэлтийн аймгийн зөвлөл дүрэмд заасан чиг үүргээ хэрэгжүүлээгүй зэргээс аймгийн бодлого төлөвлөлт хангалтгүй байна.
- Хөдөлмөр эрхлэлттэй холбоотой тоон мэдээллийг цуглуулах, нэгтгэн дүгнэх, дүн шинжилгээ хийх, түүнд үндэслэн бодлого, төлөвлөлтийн арга хэмжээг авч хэрэгжүүлэх ажил хийгдэхгүй байна.
- ХЭДС-аас олгож байгаа зээлийн хэмжээ үйл ажиллагаа явуулахад хүрэлцдэггүй, төсөл хэрэгжүүлэгч нар нь санхүүгийн болон бизнес эрхлэх мэдлэг дутмаг байдлаас төслийн хэрэгжилт хангалтгүй.
- ХЭДС-аас олгосон зээлийг эргэн төлөхгүй тохиолдолд Монгол банкны чанаргүй зээлийн мэдээллийн санд ордоггүй, хариуцлагын ямар нэгэн зохицуулалтгүйгээс зээлийн эргэн төлөлт хангалтгүй байна.
- Хөдөлмөр эрхлэлтийг дэмжихтэй холбоотой төсвийг бүс нутаг, сумдын онцлог, хүн ам, хөдөлмөр эрхлэлттэй холбоотой үзүүлэлт, тоон мэдээлэлд үндэслэн хуваарилахгүй байна.
- Ажил олоход хүндрэлтэй, ажилгүйдэлд өртөж болзошгүй иргэдийг тодорхойлон, тоон мэдээллийг цуглуулж, нэгтгэн дүгнэж, дүн шинжилгээ хийхгүй байна.



Зөвлөмж

Аудитын нотлох баримт, аудитын дүгнэлтэд үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг дор дурдсан байгууллага, албан тушаалтанд зөвлөж байна.

Аймгийн Засаг даргад:

- Аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэл, Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэхтэй холбоотой зорилт арга хэмжээг ХХҮГ-аас хэрэгжүүлж буй төсөл хөтөлбөртэй уялдуулан нэмэлт өөрчлөлт оруулах.
- Хөдөлмөр эрхлэлттэй холбоотой бодлогын баримт бичгийг боловсруулахдаа тооцоо судалгаа, тоон мэдээлэлд үндэслэн зорилт, шалгуур үзүүлэлтийг тогтоон, жил бүрийн хүрэх түвшин, хийгдэх ажлын төлөвлөгөөг нарийвчлан боловсруулж, хэрэгжилтэд тогтмол хяналт шалгалт хийн, үр дүнг тооцон ажиллаж байх нь зүйтэй байна.

Аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газарт:

- Төсөл хөтөлбөр, төсвийг сумд, бүс нутгийн онцлог шинж чанар, хүн ам, хөдөлмөр эрхлэлттэй холбоотой үзүүлэлтүүдийг харгалзан үзэж, тооцоо судалгаанд үндэслэн боловсруулан хуваарилж байх шаардлагатай байна;
- Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэхтэй холбоотой ажил хариуцаж байгаа байгууллагуудтай хамтран ажиллаж, тоон мэдээллийг нэгтгэн, дүн шинжилгээ хийж, үр дүнг тооцох;
- Санхүүгийн дэмжлэг авсан төсөл хэрэгжүүлэгч нарын үйл ажиллагаанд тогтмол хяналт шалгалт хийн, санхүү, бизнесийн мэдлэг олгох сургалт, сурталчилгааг хийж, төслийг амжилттай хэрэгжүүлэх, зээлийн эргэн төлөлтийг сайжруулахад анхаарч ажиллах;
- Төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтэд тогтмол хяналт хийж, үр дүнг үнэлэн, хэрэгжилт хангалтгүй байгаа зорилт, арга хэмжээний шалтгаан нөхцөлийг тодорхойлон, цаашид сайжруулан ажиллах талаар төлөвлөж байх;
- Ажил олоход хүндрэлтэй, идэвхгүй ажил хайгч иргэдийн тоон мэдээллийг цуглуулж, дүн шинжилгээ хийн эдгээр хүмүүст чиглэсэн ажил мэргэжлийн чиг баримжаа олгох сургалт зохион байгуулж, үр дүнг тооцон ажиллах;

Аймгийн Хөдөлмөр эрхлэлтийн аймгийн зөвлөлд:

- Хөдөлмөр эрхлэлтийн аймгийн зөвлөл нь дүрэмд заасан чиг үүргээ хэрэгжүүлж, хөдөлмөр эрхлэлтийн бодлого, хөтөлбөр боловсруулах, түүний хэрэгжилт, үр дүнг тооцох, хөдөлмөр эрхлэлт хариуцсан байгууллагуудыг удирдлага зохион байгуулалтаар хангаж, үйл ажиллагааны уялдаа холбоог сайжруулан ажиллах;



Дээд шатны байгууллагад хүргүүлэх санал

ҮАГ-аар дамжуулан холбогдох яаманд стандарт, дүрэм журам аргачлал боловсруулах, өөрчлөлт оруулах саналыг уламжилж байна.

Үндэслэл 1:

Монгол банкны мэдээллийн санд зээлдэгчийн мэдээлэл бүртгэдэггүй, зээлийг эргэн төлөхгүй тохиолдолд хүлээлгэх хариуцлагын зохицуулалт байхгүй нь зээл эргэн төлөлт хангалтгүй байгаад нөлөөлж байна.

/Дэлгэрэнгүйг тайлангийн 2-р бүлгийн 2.3.1-р хэсгээс харна уу/

Санал 1: Хугацаа хэтэрсэн зээлдэгчийн мэдээллийг Монгол банкны чанаргүй зээлийн мэдээллийн санд оруулдаг болох талаар холбогдох байгууллагад зөвлөмж хүргүүлэх;

Үндэслэл 2:

Хөдөлмөр эрхлэлт хариуцсан ажилтан нь үйл ажиллагаандаа шаардлагтай тоон мэдээллийг холбогдох байгууллагуудаас гаргуулан авах, ХБИ ажиллуулаагүйн төлбөрийг төлүүлэх талаар ААН байгууллагад шаардлага тавихад хүндрэлтэй байна.

/Дэлгэрэнгүйг тайлангийн 2-р бүлгийн 2.3.1-р хэсгээс харна уу/

Санал 2: ХХҮГ-ын хөдөлмөр хариуцсан албан хаагчид хөдөлмөр эрхлэлттэй холбоотой мэдээллийг холбогдох байгууллагаас авах, шаардлага тавих, түүнийг хэрэгжүүлээгүй тохиолдолд хариуцлага хүлээлгэдэг эрхтэй байх эрх зүйн зохицуулалтыг холбогдох хууль, журамд тусгах шаардлагатай талаар холбогдох байгууллагад зөвлөмж хүргүүлэх;

Үндэслэл 3:

Хөдөлмөрийн зах зээлийн нэгдсэн системээс гаргуулсан тоон мэдээлэл нь зөрүүтэй, иргэний ажилд орсон, гарсан хөдөлгөөний мэдээлэл тодорхойгүй, мэргэжлийн ангилал тодорхой бус зэрэг дутагдалтай байна.

/Дэлгэрэнгүйг тайлангийн 1-р бүлгийн 1.2-р хэсгээс харна уу/

Санал 3:

Хөдөлмөрийн зах зээлийн нэгдсэн системийн алдаа, дутагдлыг арилгах, Улсын бүртгэлийн хэлтэс, Татварын хэлтэс, Нийгмийн даатгалын хэлтэс зэрэг төрийн байгууллагуудын мэдээллийн сантай холбох талаар холбогдох байгууллагад зөвлөмж хүргүүлэх;



Санал, тайлбар

Төрийн аудитын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д заасны дагуу аудитын тайлангийн төслийг аймгийн ХХҮГ-т танилцуулж санал тайлбарыг авлаа.



ДУНДГОВЬ АЙМГИЙН ХӨДӨЛМӨР, ХАЛАМЖИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГАЗАР

48090 Дундговь аймаг, Сайнцагаан сум

Утас: (+976) 7059-3986, 7059-2480

Факс: (+976) 7059-3986

И-мэйл: www.Dundgovi.hudulmur-halamj.gov.mn

2022. 05. 05 № 153


танай _____-ны № _____-т

ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАРТ

Аудитын тайлангийн төсөлтэй танилцлаа.
Санал тайлбар байхгүй.

Акт, албан шаардлага, зөвлөмжийг
хэрэгжүүлж ажиллана.

ДЭД ДАРГА



Ц.СУВДАНТУЯА

482203255

ЭДИЙН ЗАСАГ НИЙГМИЙГ ХӨГЖҮҮЛЭХ ҮНДСЭН ЧИГЛЭЛ, ЗАСАГ ДАРГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙН 2016-2021 ОНД ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТТЭЙ ХОЛБООТОЙ ТУСГАСАН ЗААЛТ

Хавсралт №1

Бодлогын баримт бичгийн нэр	Хөдөлмөр эрхлэлттэй холбоотой асуудлууд	Тусгагдсан заалтууд	Хяналт шалгалт хийгдсэн эсэх, хэрэгжилтийн хувь	Хүрэх түвшин, шалгуур үзүүлэлт хэмжих боломжтой эсэх, санхүүжилтийн эх үүсвэр, мөнгөн дүн	Бодлогын баримт бичгийн хоорондын уялдаа холбоо	Хөдөлмөр эрхлэлтийн бодлого, хөтөлбөрүүдтэй уялдаж байгаа эсэх
АЗДУАХ 2016-2020	6	6	100	*6 заалтын 3 нь санхүүжилтийн эх үүсвэр тодорхойгүй *Хүрэх түвшин тусгасан боловч бодитой бус * шалгуур тодорхойгүй ,	Хувиараа хөдөлмөр эрхлэх хүсэлтэй, санхүүгийн дэмжлэг шаардлагатай ажилгүй иргэдийг төсөл хөтөлбөрт хамруулан 50-иас доошгүй шинэ ажлын байрыг бий болгоно.	3
ЭЗНХҮЧ 2020-2024	7	4	100	Санхүүжилтийн эх үүсвэр тодорхой Хүрэх түвшин тусгасан боловч бодитой бус Шалгуур тодорхой	Хөдөлмөрийн зах зээлийн эрэлт нийлүүлэлтийн дагуу 300 хүртэл мэргэжилтэй ажилчин бэлтгэн, 2000-аас доошгүй иргэдийг сул чөлөөтэй ажлын байранд зуучилна.	3
ЭЗНХҮЧ 2017	2	Нийтийн төлөөх бүтээн байгуулалтын ажилд ажилгүй зорилтот бүлгийн иргэдийг хамруулна.	93.7	Санхүүжилтийн эх үүсвэр тодорхойгүй *Хүрэх түвшин тусгасан , * шалгуур тодорхойгүй ,	2	1
ЭЗНХҮЧ 2018	7	7	100	Санхүүжилтийн эх үүсвэр тодорхойгүй *Хүрэх түвшин тусгасан , * шалгуур тодорхой ,	4	5
ЭЗНХҮЧ 2019	0	Хөдөлмөр эрхлэлт нийгмийн хамгааллын чиглэлээр 4 заалтын 8 шалгуур үзүүлэлт тусгагдсан боловч хөдөлмөр эрхлэлтийг дэмжих,		Хөдөлмөр эрхлэлттэй холбоотой заалт тусгагдаагүй байна.		

		ажилгүйдлийг бууруулахтай холбоотой заалт тусгагдаагүй байна.				
ЭЗНХҮЧ 2020	3		100	Санхүүжилтийн эх үүсвэр тодорхойгүй *Хүрэх түвшин тусгасан , * шалгуур тодорхой ,	Хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээний шинэлэг хэлбэр, арга хэмжээг турших замаар зорилтод бүлгийн иргэдийн тогтвортой ажил эрхлэлтийг дэмжих төсөл боловсруулан хэрэгжүүлэх, Ур чадварын сургалтад хамрагдсан иргэдийг байнгын ажлын байртай болгох хувь /10/	Хөдөлмөр эрхлэлтийн бодлого, хөтөлбөрүүдтэй уялдаагүй байна.
ЭЗНХҮЧ 2021	11	310 ба түүнээс доош оноотой өрхийн хөдөлмөрийн чадвартай иргэдийг сул чөлөөтэй ажлын байранд зуучлах	100		310 ба түүнээс доош оноотой өрхийн хөдөлмөрийн чадвартай иргэдийг сул чөлөөтэй ажлын байранд зуучлах	
Аймгийн 2021-2025 хөгжүүлэх үндсэн чиглэл	5	5		Санхүүгийн эх үүсвэр тодорхойлсон, Хүрэх түвшин тусгасан, шалгуур үзүүлэлт тодорхой	Заалтууд уялдаа холбоотой тусгагдсан.	5

Хавсралт №2

АЙМГИЙН ПОЛИТЕХНИКИЙН КОЛЛЕЖИЙН 2016-2021 ОНЫ БАТЛАГДСАН ТӨСӨВ, ТӨГСӨГЧДИЙН ТОО

2016				2017				2018			
Батлагдсан төсөв	Төсвийн гүйцэтгэл	Төгсөгчдийн тоо	Ажилд орсон төгсөгчдийн тоо	Батлагдсан төсөв	Төсвийн гүйцэтгэл	Төгсөгчдийн тоо	Ажилд орсон төгсөгчдийн тоо	Батлагдсан төсөв	Төсвийн гүйцэтгэл	Төгсөгчдийн тоо	Ажилд орсон төгсөгчдийн тоо
1,226,414	1,194,454	437	321	1,527,165	1,513,417	350	250	1,471,125	1,463,303	344	276
2019				2020				2021			
Батлагдсан төсөв	Төсвийн гүйцэтгэл	Төгсөгчдийн тоо	Ажилд орсон төгсөгчдийн тоо	Батлагдсан төсөв	Төсвийн гүйцэтгэл	Төгсөгчдийн тоо	Ажилд орсон төгсөгчдийн тоо	Батлагдсан төсөв	Төсвийн гүйцэтгэл	Төгсөгчдийн тоо	Ажилд орсон төгсөгчдийн тоо
1,766,679	1,739,662	240	191	1,972,905	1,801,806	281	203	1,905,333	1,894,129	281	88

Аймгийн засаг дарга, ХХҮЕГ болон ХНХС-тай 2016-2021 оны байгуулсан гэрээний хэрэгжилт

	2016		2017		2018		2019		2020		2021	
	Хөдөлмөр эрхлэлттэй холбоотой заалтын тоо	Хэрэгжилтийн хувь	Хөдөлмөр эрхлэлттэй холбоотой заалтын тоо	Хэрэгжилтийн хувь	Хөдөлмөр эрхлэлттэй холбоотой заалтын тоо	Хэрэгжилтийн хувь	Хөдөлмөр эрхлэлттэй холбоотой заалтын тоо	Хэрэгжилтийн хувь	Хөдөлмөр эрхлэлттэй холбоотой заалтын тоо	Хэрэгжилтийн хувь	Хөдөлмөр эрхлэлттэй холбоотой заалтын тоо	Хэрэгжилтийн хувь
Аймгийн Засаг даргын ХНХЯ-ны сайдтай байгуулсан гэрээ	7	94	3	97.6	5	88	3	92.9	7	91.4	5	97.2
ХХҮГ-ын ХХҮЕГ-ын даргатай байгуулсан гэрээ	4	77.1	4	99.3	7	100	7	100	6	95	6	93.1

Жижиг дунд үйлдвэрлэл, Сум хөгжүүлэх сангийн 2016-2021 оны зарцуулсан төсөв, бий болсон ажлын байрны тоо

№	Сумын нэр	2016			2017			2018			2019			2020				2021	
		Зарцуулсан төсөв			Зарцуулсан төсөв			Зарцуулсан төсөв			Зарцуулсан төсөв			Зарцуулсан төсөв				Зарцуулсан төсөв	
		ЖДҮ	СХС	Бий болгосон ажлын байр	ЖДҮ	СХС	Бий болгосон ажлын байр	ЖДҮ	СХС	Бий болгосон ажлын байр	ЖДҮ	СХС	Бий болгосон ажлын байр	ЖДҮ	СХС	Бий болгосон ажлын байр	ЖДҮ	СХС	Бий болгосон ажлын байр
1	Сайнцагаан	25,000.0	299,500	26		495,800	48	450,000	374,242	61	750,000.00	443,300	92	369,700	466,740	83		459,200	16
2	Адаацаг		92,500	12		72,000	19		152,300	9		89,000	15	0	32,500	16		82,000	7
3	Баянжаргалан		0			41,500	10		10,000	8		139,700	10	0	23,000	9		101,500	3
4	Говь-Угтаал		0			76,200	22		0	0		35,000	20	0	69,000	12		0	
5	Гурвансайхан		7,277	8		33,000	5		29,199	7		100,000	12	0	0	0		0	
6	Дэлгэрхангай		0			32,000	9		0	0		136,500	33	0	0	0		0	
7	Дэлгэрцогт		0			52,850	16		40,000	8		87,786	25	0	64,000	17		35,000	3
8	Дэрэн		0			0			0	0		0	0	0	87,000	29		0	
9	Луус		0			62,500	18		20,000	3		62,000	6	0	110,600	18		0	
10	Өлзийт		0			12,000	5		37,000	9		116,200	19	50,700	45,555	26		0	
11	Өндөршил		0			24,000	7		10,000	2		20,000	6	0	33,000	8		121,830	6
12	Сайхан-Овоо		15,000	2		20,000	13		0	0		75,500	32	0	56,000	9		0	
13	Хулд		25,000	6		74,000	20		48,500	17		60,500	13	30,000	102,500	26		0	
14	Цагаандэлгэр		30,541	7		0	0		0	0		137,000	16	20,000	63,500	16		0	
15	Эрдэнэдалай		1,500	1		0	0		127,000	22		94,000	14		150,000	40		0	
16	Нийт		471,319	62	0	995,850	192	450,000	848,241	146	750,000	1,596,486	313	470,400	1,303,395	309	0	799,530	35

Төвийн бүсийн аймгуудын 2016-2020 оны харьцуулсан судалгаа

Аймгийн нэр	2016 он					2017 он					2018 он				
	Зарцуулсан төсөв	Ажиллах хүч	15 ба түүнээс дээш насны хүн ам	Хөдөлмөр эрхлэлтийн түвшин	Ажилгүйдлийн түвшин	Зарцуулсан төсөв	Ажиллах хүч	15 ба түүнээс дээш насны хүн ам	Хөдөлмөр эрхлэлтийн түвшин	Ажилгүйдлийн түвшин	Зарцуулсан төсөв	Ажиллах хүч	15 ба түүнээс дээш насны хүн ам	Хөдөлмөр эрхлэлтийн түвшин	Ажилгүйдлийн түвшин
Өмнөговь	156,000	28,370	44,349	59.1	14.3	341,400	30,292	45,542	57.5	16.4	515,000	32,019	47,700	64	7.3
Дорноговь	226,000	31,177	46,183	61.5	9.9	314,050.00	33,439	47,220	65.5	6	507,000	31,340	47,662	63.8	5.3
Говьсүмбэр	118,222	6,239	11,446	50.8	18.1	66,375	7,711	11,688	63.6	7.8	234,000	7,468	11,584	52.8	11.7
Төв	269,000	49,040	66,120	75.5	2.7	694,000	50,257	66,663	77	3.2	855,000	50,992	66,155	76.9	2.6
Дундговь	225,000		32,399	69.7	5.1	291,500.00		32,925	74.2	4.4	420,000		32,987	75.6	5
ДҮН	994,222	114,826	200,497	317	50	1,707,325	121,699	204,038	338	38	2,531,000	121,819	206,088	333	32

2019 он					2020 он				
Зарцуулсан төсөв	Ажиллах хүч	15 ба түүнээс дээш насны хүн ам	Хөдөлмөр эрхлэлтийн түвшин	Ажилгүйдлийн түвшин	Зарцуулсан төсөв	Ажиллах хүч	15 ба түүнээс дээш насны хүн ам	Хөдөлмөр эрхлэлтийн түвшин	Ажилгүйдлийн түвшин
589,000	32,473	47,596	66.7	6	297,000	30,176	47,751	67.8	5.6
579000	32,985	47,494	66.3	3.9	300980	29,316	48,277	65.9	4.1
279500	8,058	11,442	67.2	10	189000	7,496	11,746	61	9.9
924830	40,760	63,747	65.1	4.1	464700	43,868	61,091	68.8	2.8
636,985		32,561	71.1	4.9	230,600		32,758	68.1	3.1
3,009,315	114,276	202,840	336	29	1,482,280	110,856	201,623	332	26

Сумдын 2016-2021 оны харьцуулсан судалгаа

Сумдын нэр	15 ба түүнээс дээш насны хүн ам						Ажиллагчдын тоо				
	2016	2017	2018	2019	2020	2021	2017	2018	2019	2020	2021
Адаацаг	2026	2072	2029	1958	1950	2072	187	177	140	116	189
Баянжаргалан	819	826	877	858	895	826	241	206	206	259	291
Говь-Угтаал	1149	1148	1134	1106	1122	1148	187	391	240	192	399
Гурвансайхан	1532	1570	1534	1560	1556	1570	216	168	151	174	185
Дэлгэрхангай	1581	1610	1593	1581	1609	1610	171	184	150	200	218
Дэлгэрцогт	1176	1214	1206	1178	1184	1214	156	141	111	147	159
Дэрэн	1470	1486	1487	1474	1496	1486	156	152	117	143	145
Луус	1288	1318	1336	1331	1367	1318	136	172	129	162	189
Өлзийт	1738	1714	1736	1712	1753	1714	153	155	146	166	165
Өндөршил	1059	1045	1050	1027	1066	1045	162	168	168	158	187
Сайнцагаан	10656	10878	10878	10649	10717	10878	4105	4155	4633	4127	3827
Сайхан-Овоо	1528	1567	1545	1508	1525	1567	146	141	147	152	164
Хулд	1674	1721	1722	1697	1719	1721	189	180	151	192	221
Цагаандэлгэр	724	749	746	723	748	749	133	112	87	119	130
Эрдэнэдалай	3979	4007	4024	3954	4051	4007	347	352	219	316	354
Нийт	32,399	32,925	32,897	32,316	32,758	32,925	6,685	6,854	6,795	6,623	6,823

Сумдын нэр	Ажилгүйчүүдийн тоо					Ажлын байрны захиалгын тоо					
	2017	2018	2019	2020	2021	2016	2017	2018	2019	2020	2021
Адаацаг	40	18	14	23	4	12	31	56	32	19	138
Баянжаргалан	28	24	15	16	16	0	31	27	26	23	37
Говь-Угтаал	102	56	19	53	17	3	46	79	50	30	33
Гурвансайхан	31	27	37	26	0	6	51	34	125	39	13
Дэлгэрхангай	27	24	22	39	28	9	25	45	44	20	30
Дэлгэрцогт	43	36	12	25	17	20	22	31	8	15	95
Дэрэн	53	180	21	19	16	1	56	60	34	20	57
Луус	48	41	11	7	19	2	13	45	51	18	96
Өлзийт	17	18	11	1	1	6	28			12	
Өндөршил	49	21	41	16	39	9	15	53	85	52	34
Сайнцагаан	380	363	115	185	81	204	209	188	166	236	83
Сайхан-Овоо	24	25	24	18	19		26	20	9	15	17
Хулд	34	99	28	53	46	2	36	32	41	28	21
Цагаандэлгэр	35	18	13	9	6	2		28	27		20
Эрдэнэдалай	35	112	65	41	25	11	89	77	25	45	44
Нийт	946	1,062	448	531	334	287	678	775	723	572	718

Хавсралт №7

Төрөөс хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх чиглэлээр авч хэрэгжүүлсэн төсөл, хөтөлбөрийн батлагдсан төсөв, төсвийн гүйцэтгэл

/сая төгрөгөөр/

№	Төсөл, хөтөлбөрийн нэр	2016 он		2017 он		2018 он		2019 он		2020 он		2021 он		Санхүүжилтийн эх үүсвэр			Нийт дүн
		Батлагдсан төсөв	Төсвийн гүйцэтгэл	Батлагдсан төсөв	Төсвийн гүйцэтгэл	Батлагдсан төсөв	Төсвийн гүйцэтгэл	Батлагдсан төсөв	Төсвийн гүйцэтгэл	Батлагдсан төсөв	Төсвийн гүйцэтгэл	Батлагдсан төсөв	Төсвийн гүйцэтгэл	Төсөв	Зээл, тусламж	Бусад	
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14	15	16	17	18
1	Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөх үйлчилгээг дэмжих хөтөлбөр	17.4	17.4											17.4			17.4
2	Аж ахуй эрхлэх, бичил бизнесийг дэмжих хөтөлбөр	115.0	115.0											292.2			292.2
3	Хөдөлмөр эрхлэлтийн ур чадвар олгох, ажлын байрыг дэмжих хөтөлбөр	40.0	40.0	29.1	14.8									158.5			158.5
4	Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр	42.2	42.2	61.5	52.3									103.7			103.7
5	Хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрыг дэмжих хөтөлбөр	56.0	56.0			57.1	44.5	49.0	47.2	56.0	55.6	83.7	65.9	358.5			358.5
6	Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр	226.3	226.3	141.2	137.8	236.2	234.0	270.2	232.0	29.0	29.0			1,102.9			1,102.9
7	Нийтийг хамарсан ажил зохион байгуулах хөтөлбөр	73.7	73.7											73.7			73.7
8	Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээний төсөл	11.4	11.4											11.4			11.4
9	Хөдөлмөрт бэлтгэх, хөдөлмөр эрхлэлтийн ур чадвар олгох хөтөлбөр					23.9	10.1	19.3	8.6	1.1	1.1	7.6	7.2	51.9			51.9
10	Ажлын байрыг дэмжих хөтөлбөр			275.9	235.8	218.3	194.0	404.8	328.2	174.9	172.2			1,073.9			1,073.9
11	Залуучуудын хөдөлмөр эрхлэлт, гарааны бизнесийг дэмжих хөтөлбөр					74.8	63.3	173.0	163.0	52.6	50.2	18.0	18.0	318.4			318.4
12	Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээг хөгжүүлэх хөтөлбөр			21.5	17.0	28.2	28.2	33.6	24.6	30.0	28.9	35.4	35.4	148.7			148.7
13	Цар тахлын үед аж ахуй эрхлэгчдийн үйл ажиллагааг сэргээх хөтөлбөр											198.1	198.1	198.1			198.1
14	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр			55.5	41.8									55.5			55.5
15	Ажилд зуучлах үйлчилгээ			4.7	1.1	9.1	8.4	12.3	9.9	1.0	1.0	3.9	0.9	31.0			31.0
16	Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөх үйлчилгээ			4.6	3.7	17.0	16.9	21.4	8.7	2.2	2.2	12.0	7.0	57.2			57.2
17	Бусад төсөл, хөтөлбөр: Хөдөлмөрийн зах зээлийг дэмжих Орон нутгийн санаачилгын төсөл									49.3	19.9	54.2	36.8	103.5	66.5		170.0
ДҮН		582.0	582.0	594.0	504.3	664.6	599.4	983.6	822.2	396.1	360.1	412.9	369.3	4,156.5	66.5	-	4,223.0

Монгол Улс, Дундговь аймаг 48090, Сайнцагаан сүм, Нарлаг
баг, Нутгийн удирдлагын ордон Утас/Факс: 70-59-24-39
E-mail: dundgovi@audit.gov.mn ОН